

**“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ ТООЦОХ НОРМ”
(ЗЗБНБД 81-013-2026)-ЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Авто замын норм, нормативын сангийн хөрөнгөөр 2024–2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Авто зам, замын байгууламжийн төсөв бодох норм” (ЗЗБНБД 81-013-2019)-ыг шинэчлэн боловсруулах ажлыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захиалгаар “Монголын авто замчдын холбоо” ТББ гүйцэтгэсэн. Энэ норм нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд түүнээс хойш 2022 оны А/20, 2023 оны А/257, 2024 оны А/63 болон А/243 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлтүүд орж, салбарын төсөв, үнэ бүрдлийн тогтолцоо, нормын аргачлал, тооцооллын зарчимд тодорхой шинэчлэлүүдийг тусган мөрдөгдөж байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн өөрчлөлт, салбарын норм, нормативын шинэчлэлтэй холбоотойгоор нормын зардлын бүтэц, аргачлалыг шинэчлэн тодорхойлох зайлшгүй шаардлага үүссэн. Үүнд:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалын дагуу батлагдсан хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтын дагуу авто замын салбарын 3 талт хэлэлцээрийн дагуу тогтоосон нэмэгдэл цалинг төсөвт тооцох,
2. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 471 дүгээр тогтоолын дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалтын дагуу нийгмийн даатгалын шимтгэл тооцох,
3. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын дагуу ажилтнуудад үйлчлэх зардлын нормативыг шинэчлэх,
4. Авто замын тухай хуульд нийцүүлэн техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлын хэмжээг шинэчлэн тогтоох,
5. Монгол Улсад олон улсын банк, санхүүгийн зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдэд нэгж үнэд суурилсан санхүүжилтийн аргачлал хэрэглэгддэг бөгөөд уг аргачлалыг дотоодын төсөл, хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх,
6. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан шаардлагыг нормд тусгах гэх мэт.

Дээрх хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл хөлс, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, ажилтнуудад үйлчлэх зардал болон техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлыг нормын төсөлд нэг мөр, иж бүрэн байдлаар тусган боловсруулсан.

Авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг тооцох нормыг хууль эрх зүй, зах зээлийн нөхцөл байдал, салбарын эрх зүйн орчны өөрчлөлттэй уялдуулан шинэчилснээр төсвийн төлөвлөлтийг бодитой, ил тод, нэгдсэн аргачлалтай болгох, төсвийн сахилга батыг сайжруулах нөхцөл бүрдэж байна. Нормын шинэчлэл нь өртгийг зохиомлоор нэмэгдүүлэх зорилгогүй бөгөөд барилга, засварын ажлын явцад бодитоор үүсдэг зардлуудыг бүрэн, ил тод, нэгдсэн аргачлалаар тооцох боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.

Шинэчилсэн нормыг мөрдсөнөөр төсөвт өртгийг бодитой тооцох, төлөвлөлтийн шатанд эрсдэлийг урьдчилан тооцох, гүйцэтгэлийн шатанд нэмэлт санхүүжилт үүсэх нөхцөлийг бууруулах, төсөв тооцооны ил тод, ойлгомжтой, жигд байдлыг хангах боломж бүрдэнэ. Судалгаа, тооцооллын үр дүнгээс үзэхэд шинэ нормыг хэрэгжүүлснээр авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртөгт 10 орчим хувийн өөрчлөлт гарч байгаа нь өмнө нь тооцдоггүй байсан зардлыг бүрэн тусгасантай холбоотой юм. Мөн “Авто зам, замын байгууламжийн төсөв бодох норм” (ЗЗБНБД 81-013-2019) батлагдсан 2019 оноос хойших зах зээлийн нөхцөл байдал, үнийн өсөлт, холбогдох тушаал, журмын өөрчлөлтөөс шалтгаалан зарим зардлын нормативт өөрчлөлт орсон.

Нормыг шинэчлэн боловсруулснаар гүйцэтгэлийн шатанд үүсдэг нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ буурч, батлагдсан төсөвт өртөг давж гүйцэтгэгдэх эрсдэл хязгаарлагдах, улмаар улсын төсөв төлөвлөлтийн чанар, сахилга бат сайжрах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн ажиллах нөхцөл, байгаль цаг агаарын нөлөөллөөс үүсэх эрсдэлийг төвөгшлийн итгэлцүүр зэрэг зохицуулалтын хэрэгслээр удирдах боломжийг тусгасан.

Нормын төслийг боловсруулахдаа олон улсын жишиг, туршлагыг харгалзан үзэж, ОХУ болон БНХАУ-ын авто замын төсөв, үнэ бүрдлийн тогтолцоонд харьцуулсан судалгаа хийгдсэн. Судалгаагаар эдгээр улс орнуудад хөдөлмөр, машин механизм, материалын нөөцөд суурилсан норматив тооцоолол давамгайлж, бүс нутгийн онцлогт тохирсон коэффициент, индексийг ашиглан төсөвт өртгийг тодорхойлдог нийтлэг зарчим үйлчилж байна.

Энэхүү харьцуулсан судалгааны үр дүнг авто замын салбарын норм, нормативтай уялдуулан авч үзэж, үндэсний онцлог нөхцөлд нийцсэн, олон улсын нийтлэг зарчимд тулгуурласан зардлын тооцооллын аргачлалыг боловсруулсан. Үүний нэг жишээ нь төсөвт өртгийн тооцоог нэгж үнээр тооцох аргачлалыг боловсруулж нормын төсөлд тусгасан. Энэ нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт бүрэн нийцэхээс гадна олон улсын практикт түгээмэл хэрэглэгддэг үнэ бүрдлийн суурь зарчимтай уялдсан, харьцуулах боломжтой, ил тод тогтолцоог бүрдүүлж байна.

Дээрх үндэслэл, тооцоололд тулгуурлан “Авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг тооцох норм (ЗЗБНБД 81-013-2026)”-ыг шинэчлэн мөрдөх нь төсвийн төлөвлөлтийн бодит, ил тод байдал, сахилга батыг сайжруулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБОО

ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМАТИВ,
ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
НОРМ БА ДҮРЭМ**

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
ТӨСӨВТ ӨРТӨГ ТООЦОХ НОРМ
ЗЗБНБД 81-013-2026
(ТӨСӨЛ)

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
2026 ОН

Зам, тээврийн сайдын 2026 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Хууль зүй, дотоод хэргийн яамны улсын нэгдсэн бүртгэлийн 2026 оны ... дугаар сарын ... өдрийн ... дугаарт бүртгэв.

Энэхүү баримт бичгийг 2026 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн мөрдөнө.

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

Мэргэшсэн инженер, Тэргүүлэх төсөвчин	Л.БААСАНБАТ
ГИШҮҮД:	
Зөвлөх эдийн засагч, Тэргүүлэх төсөвчин	Ц.ЦЭРЭНДОРЖ
Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	Б.БАТТУЛГА
Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	Б.МАРГАД-ЭРДЭНЭ
Мэргэшсэн инженер, программист	Б.ЭРДЭНЭБАЯР
Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	Э.ЭРДЭНЭТУЯА
Авто замын инженер, Төсөвчин	Д.ЯНЖИНДУЛАМ

РЕДАКЦИЙН АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	Л.БАТХҮҮ
ГИШҮҮД:	
Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	Д.ЭНХТУЯА
Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	Б.МИНЖБАДАМ
Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	С.БАТСҮХ
Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	Л.ЭРДЭНЭБААТАР
Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	Ө.БААСАНСҮРЭН
Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	Б.НЯМЖАРГАЛ
Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	Ц.ЦОЛМОН
Авто замын Мэргэшсэн инженер	Ж.БАЯРСАЙХАН
Авто замын инженер	Б.ЛХАГВАДОРЖ

ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМАТИВ, ТЕХНИКИЙН
БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО

**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
НОРМ БА ДҮРЭМ**

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
ТӨСӨВТ ӨРТӨГ ТООЦОХ НОРМ

ЗЗБНбД 81-013-2026

(ТӨСӨЛ)

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

2026 ОН

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМ БА ДҮРЭМ
АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ ТООЦОХ НОРМ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү норм нь ажлын зураг төсөл, техникийн шаардлага болон гэрээний бусад холбогдох баримт бичигт тулгуурлан, Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт, төсвийн суурь нормыг үндэслэн авто зам, замын байгууламжийн төсөвт өртгийг тодорхойлоход ашиглагдана.
2. Энэ нормын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт авто зам, замын байгууламжийг барих, засварлах, шинэчлэх (цаашид барилга, засвар гэх) ажлын төсөвт өртгийг тодорхойлох арга зүй, зарчим, дарааллыг тогтооход оршино.
3. Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжих авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн тооцоонд салбарын төрөл, хөрөнгийн эх үүсвэр, өмчийн хэлбэр, харъяаллаас үл хамааран энэ нормыг мөрдөнө.
4. Энэ нормын дагуу тооцоолсон төсөвт өртгийн тооцоог дараах ажлуудад хэрэглэнэ. Үүнд:
 - ✓ Улсын болон орон нутгийн төсөв, нийслэлийн төсөв, Замын сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө болон эдгээртэй адилтгах төсвийн бус эх үүсвэрээр санхүүжих төсөл, хөтөлбөрүүд,
 - ✓ Хувийн болон гадаадын компанийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлууд,
 - ✓ Дээрх ажлуудын хөрөнгө оруулалт, санхүүжилт, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, тендерийн баримт бичиг боловсруулах, сонгон шалгаруулалт явуулах,
 - ✓ Хууль, тогтоомжийн дагуу шууд гэрээгээр гүйцэтгэх ажлын сонгон шалгаруулалт болон бусад холбогдох үйл ажиллагаа,
5. Энэ нормыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан авто замын салбарын үнэ бүрдэл, төсвийн норм, нормативууд, эрх зүйн баримт бичгийг үндэслэн боловсруулав.

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ нормд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1. “Төсөвт өртөг” гэж зураг төслийн баримт бичигт үндэслэн, төсөвт өртөг тооцох нормын дагуу тодорхойлсон авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардагдах нийт мөнгөн хөрөнгийн нийлбэрийг;
2. “Шууд зардал” гэж барилга, засварын ажлыг гүйцэтгэх явцад үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардагдах нийт цалин, материал, машин механизм, тээвэр, ажилтнуудад үйлчлэх зардал болон эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг;
3. “Төсвийн норм” гэж барилга, засварын ажлын нэгж хэмжигдэхүүнд тогтоосон нөөцийн хэмжээг /ажилтны хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллах хугацаа, материалын хэрэгцээ/ норматив байдлаар тогтоосон баримт бичиг;
4. “Төсвийн норматив” гэж төсөвт өртгийг тодорхойлоход ашиглагдах норм, жишиг үнэ, тариф, үнэлгээний эмхэтгэл болон холбогдох бусад баримт бичгийн цогц;
5. “Томсгосон норм” гэж нэг төрлийн хэд хэдэн ажилбарыг нэгтгэн багцалсан байдлаар илэрхийлсэн, урьдчилсан болон анхан шатны төсөв, ТЭЗҮ-д ашиглагдах норм;
6. “Объектын төсөв” гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах шууд зардлын тооцоо;
7. “Барилга угсралтын ажлын төсөв” гэж объектын төсөв буюу шууд зардалд үндэслэн удирдлага, зохион байгуулалтын зардал, ашгийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал, даатгалын зардлыг нэмж тооцсон төсөв;
8. “Нэгдсэн төсвийн тооцоо” гэж барилга, засварын ажлыг зураг төслийн дагуу иж бүрэн гүйцэтгэхэд шаардагдах объектын төсөв (шууд зардал), барилга угсралтын ажлын зардал болон бусад зардлыг нэгтгэн боловсруулсан төсвийн баримт бичиг;
9. “Төсөвт өртөг” гэж зураг төсөл, техникийн шаардлага болон бусад холбогдох баримт бичигт үндэслэн, төсөвт өртөг тооцох нормын дагуу тооцсон, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад шаардлагатай нийт мөнгөн хөрөнгийн хэмжээг;
10. “Хөдөлмөр зарцуулалт” гэж тухайн нэгж ажлыг гүйцэтгэхэд шаардагдах ажилтны зарцуулах хугацааг хүн/цагаар илэрхийлсэн норматив үзүүлэлт;
11. “Нийт цалин” гэж барилга, засварын ажлыг гүйцэтгэхэд оролцож буй ажилтнуудын үндсэн болон нэмэгдэл цалин, нэмэгдэл хөлс, алслалтын нэмэгдлийг багтаасан цалингийн зардлын нийт дүнг;

12. “Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал” гэж ажил гүйцэтгэхэд ашиглагдах машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотой зардлыг;
13. “Материалын зардал” гэж барилга, засварын ажилд шаардагдах материал, хийц, эдлэхүүний нийт хэрэгцээ болон тэдгээрийн өртгийг илэрхийлсэн зардал;
14. “Тээврийн зардал” гэж материал, хийц эдлэхүүнийг тодорхой зайд тээвэрлэхтэй холбоотойгоор гарч буй зардлыг;
15. “Төвөгшлийн итгэлцүүр” гэж ажлын хэвийн бус буюу онцгой нөхцөлийг харгалзан төсвийн нормд хэрэглэдэг засварлах итгэлцүүр;
16. “Жишиг үнэ” гэж тухайн хугацаанд зах зээлийн дундаж түвшинг илэрхийлсэн, төсөвт өртөг тооцоход ашиглагдах албан ёсны үнэ;
17. “Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ” гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг;
18. “Захиалагчийн хяналт” гэж барилга, засварын ажлын явцад чанар, хугацаа, өртгийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор захиалагчийн зүгээс хэрэгжүүлэх хяналт, зохион байгуулалтын үйл ажиллагааг;
19. “Зураг төсөл зохиогчийн хяналт” гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд зураг төсөл зохиогчийн зүгээс хэрэгжүүлэх хяналтын үйл ажиллагааг;
20. “Нэгж үнэ” гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нэгж хэмжигдэхүүнд ногдох төсөвт өртгийг;
21. “Нийт үнэ” гэж зураг төсөлд тусгагдсан ажлын тоо хэмжээг нэгж үнээр үржүүлэн тодорхойлсон нийт төсөвт өртгийг.

1. АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮНЭ БҮРДЭЛТИЙН СИСТЕМИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Авто замын салбарын үнэ бүрдлийн тогтолцоо нь төсөвт өртгийг тодорхойлоход шаардлагатай төсвийн норм, нормативууд, холбогдох норм дүрэм, заавар болон бусад баримт бичгээс (цаашид “төсвийн норматив” гэх) бүрдэнэ.

1.2. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан төсвийн норм, үнэ, үнэлгээний эмхэтгэлүүдийг төсвийн норматив гэнэ. Төсвийн норматив нь холбогдох норм дүрэм, аргачлал, заавар, журмын хамтаар төсөвт өртгийг тодорхойлох үндэс болно.

1.3. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нэгж хэмжигдэхүүнд шаардагдах нийт нөөцийн хэмжээг (хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног

төхөөрөмж, материалын хэрэгцээ) төсвийн норм гэнэ. Төсвийн норм нь ажлыг хэвийн нөхцөлд гүйцэтгэхэд шаардагдах зайлшгүй, хүрэлцээтэй нөөцийн норматив хэмжээг тогтоож, ажлын өртгийн суурь үзүүлэлт болно.

1.4. Төсвийн нормативыг холбогдох норм дүрэм, стандарт, техникийн шаардлага, технологийн горимд үндэслэн барилга, засварын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх нөөцийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулна.

1.5. Төсвийн нормыг гадны хүчин зүйлс нөлөөлөхгүй, хэвийн нөхцөлд, ажлын технологийн дарааллын дагуу гүйцэтгэхээр боловсруулна. Хэрэв хөдөлмөрийн хэвийн бус буюу онцгой нөхцөлд (хөдөлгөөнтэй, хэт хүйтэн, хэт халуун, давчуу, битүү, газрын дор, ажиллаж буй тоног төхөөрөмжид ойр гэх мэт) ажил гүйцэтгэвэл төсвийн нормд төвөгшлийн итгэлцүүр хэрэглэнэ. Итгэлцүүрийн хувь хэмжээ, хэрэглэгдэх нөхцөлийг төсвийн суурь норм болон төсөвт өртөг тооцох нормд тодорхойлно.

1.6. Зураг төсөлд тусгагдсан нэгж ажлын өртгийг тооцоход шаардлагатай норм, норматив, холбогдох эрх зүйн баримт бичиг байхгүй тохиолдолд түүнтэй ижил төстэй ажлын норм, жишиг үнэлгээг хэрэглэнэ. Харин тохирох норм байхгүй бол тухайн ажлын төсвийн суурь нормыг зураг төслийн бүрэлдэхүүнд багтаан боловсруулж, холбогдох хууль, журмын дагуу батлуулан мөрдөнө.

1.7. Авто замын салбарын үнийн бодлого нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг бодитой тодорхойлох, хүн хүч, машин механизм, тоног төхөөрөмж, материал болон бусад нөөцийг үр ашигтай ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

1.8. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг тооцоолох үндэслэл дараах баримт бичгүүдэд тулгуурлана. Үүнд:

- ✓ Ажлын иж бүрэн зураг төсөл, техникийн шаардлага,
- ✓ Ажлын тоо хэмжээ,
- ✓ Машин механизм, тоног төхөөрөмж, материалын хэрэгцээ,
- ✓ Тээврийн зай, орон нутгийн татвар, хураамж,
- ✓ Хүчин төгөлдөр мөрдөж буй төсвийн норм, норматив,
- ✓ Үнэ бүрдлийн тогтолцооны холбогдох баримт бичгүүд багтана.

1.9. Зураг төсөл, техникийн шаардлага, бусад баримт бичгийг үндэслэн төсөвт өртөг тооцох нормын дагуу тооцсон, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад шаардагдах нийт мөнгөн хөрөнгийн нийлбэрийг төсөвт өртөг гэнэ.

1.10. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртөг нь хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох, гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын тооцоо хийх, материалын тоо хэмжээ, машин цагийн хэрэгцээ, тээвэрлэх ачааны жин, зардлыг тодорхойлох, түүнчлэн нэгдсэн төсвийн тооцоонд орсон бусад ажлын зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэгч болон захиалагчийн тайлан тэнцэл, бизнес төлөвлөгөө боловсруулахад ашиглагдах суурь тооцоо болно.

1.11. Нэгдсэн төсвийн тооцооны дүн нь ашиглалтад оруулсан авто зам, замын байгууламжийн үндсэн хөрөнгийн өртгийг тогтоох үндэслэл болно.

1.12. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг тодорхойлоход ашиглагдах төсвийн суурь нормыг нормын төрлөөр нь дараах байдлаар ангилна. Үүнд:

А. Төсвийн суурь норм:

- ✓ Барилга, засварын ажлын нэгж хэмжигдэхүүнд тогтоосон нөөцийн (ажилтны хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллах хугацаа, материалын хэрэгцээ) хэмжээг тодорхойлдог.
- ✓ Үе шатны ажил тус бүрээр нөөцийн зарцуулалтыг тооцдог тул нарийвчилсан төсөв гаргах, гүйцэтгэлийн тооцоонд шууд ашиглагдана. Жишээ нь: ургамлын хөрс хуулах, ул хөрсийг тэгшлэх, нягтруулах, далан байгуулах, асфальтбетон хучилт байгуулах зэрэг үе шатны ажил тус бүрээр нарийвчлан тооцдог.

Б. Томсгосон норм:

- ✓ Барилга, засварын нэг төрлийн ажлын хэд хэдэн ажилбарыг нэгтгэн багцалсан байдлаар илэрхийлдэг.
- ✓ Нарийвчилсан задаргаа шаарддаггүй, нэгтгэсэн бүтэцтэй. Жишээ: далан, ухмал, суурь үе, замын хучилт, тоноглол зэрэг бүлгийн ажлуудын хэд хэдэн ажилбарын нөөцийн зарцуулалтыг нэгтгэн нормын үзүүлэлт болгон гаргадаг.
- ✓ Ажлын зураг төсөл боловсруулах анхан шатны тооцоо, ТЭЗҮ болон хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоонд ашиглахад тохиромжтой.
- ✓ Томсгосон норм нь төсвийн суурь нормыг үндэслэн боловсруулагдана.

1.13. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төрлөөр тооцсон төсвийн суурь нормын (цаашид төсвийн суурь норм гэх) бүрэлдэхүүнд дараах нормууд орно. Үүнд:

- ✓ Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм (ЗЗБНБД 83-25-2023)
- ✓ Төмөрбетон гүүр, хоолойн барилгын ажлын төсвийн жишиг норм (ЗЗБНБД 83-28-2023)

- ✓ Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын төсвийн жишиг норм (ЗЗБНБД 83-26-2023)

1.14. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг тодорхойлоход дараах зардлын нормативыг ашиглана. Үүнд:

- ✓ Ажилтны тарифт цалингийн жишиг
- ✓ Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл цалин
- ✓ Тээврийн жолооч, машин механизмын операторын цалин
- ✓ Инженер техникийн ажилтны цалин
- ✓ Нэмэгдэл цалин
- ✓ Алслалтын нэмэгдэл цалин
- ✓ Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл
- ✓ Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардал
- ✓ Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал
- ✓ Удирдлага, зохион байгуулалтын зардал
- ✓ Ашгийн зардал
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал
- ✓ Даатгалын зардал
- ✓ Магадалшгүй ажлын зардал
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар
- ✓ Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал
- ✓ Захиалагчийн хяналтын зардал
- ✓ Авто замын норм, нормативын сангийн шимтгэл

1.15. Төсвийн суурь нормын эмхэтгэл нь техникийн хэсэг, төсвийн нормын хүснэгт, хавсралт, лавлах мэдээллээс бүрдэнэ. Техникийн хэсэгт төсвийн нормын эмхэтгэлүүдийг хэрхэн хэрэглэх заавар, ажил гүйцэтгэх нөхцөлийг харгалзан төсвийн нормд итгэлцүүр хэрэглэх журам, түүнчлэн ажлын тоо хэмжээг хэрхэн тодорхойлох аргачлалыг тусгана.

1.16. Төсвийн суурь нормын хүснэгт, хавсралтууд нь дараах нөөцийн норматив үзүүлэлтийг агуулна. Үүнд:

- ✓ Ажилтны ажил, мэргэжлийн нэр, мэргэжлийн зэрэг
- ✓ Ажилтны хөдөлмөр зарцуулалт (хүн/цаг)
- ✓ Машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн, ажиллах хугацаа, (маш/цаг)
- ✓ Ажил гүйцэтгэхэд хэрэглэх материал, хийц эдлэлийн нэр төрөл, хэмжих нэгжээр илэрхийлсэн зарцуулалт, нэгж хүнд

2. АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ТӨСВИЙН БАРИМТ БИЧГИЙН БҮТЭЦ

2.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийн тооцоо нь зураг төслийн баримт бичгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төсвийн суурь нормд тулгуурлан, тухайн үеийн жишиг үнэ, тариф болон зах зээлийн үнийн түвшинд үндэслэн боловсруулна.

2.2 Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэнэ. Төсвийн тооцоог зураг төсөл, ажлын тоо хэмжээ болон тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж буй холбогдох эрх зүйн баримт бичигт үндэслэн боловсруулна.

2.3. Авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг нь тооцоо хийж буй тухайн үеийн жишиг үнэд тулгуурлан тодорхойлогдсон байх ёстой. Харин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах үед тухайн санхүүгийн жилд гүйцэтгэх ажлын төсөвт өртгийг зах зээлийн үнийн хэтийн төлөвт үндэслэн тодорхойлно.

2.4. “Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д заасны дагуу материал, түүхий эд, тоног төхөөрөмжийн үнэ болон хөдөлмөрийн хөлс өөрчлөгдөх нөхцөл үүссэн бол гэрээнд заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнэд тохируулга хийж болно.

2.5. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх шилжүүлсэн байгууллага нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд ашиглах төрөл бүрийн материал, хийц, эдлэхүүний үнийн судалгаа хийж мэдээллийн сан бүрдүүлэх, шинэчлэх үүрэгтэй бөгөөд улирал тутамд олон нийтэд мэдээлнэ. Энэхүү мэдээлэл нь төсөвт өртгийн тооцоо хийх, жишиг үнэ тогтоох албан ёсны үндэслэл болно.

2.6. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн баримт бичиг нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- а) Объектын төсөв (шууд зардал)
- б) Барилга угсралтын ажлын төсөв
- в) Нэгдсэн төсвийн тооцоо
- г) Хөрөнгө оруулалтын зардлын тооцоо
- д) Нэгж үнэ ба нийт үнийн тооцоо
- е) Төсвийн нүүр, тайлбар бичиг

2.7. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн тооцооны баримт бичгийг бүрдүүлэхдээ дараах үндсэн дэс дарааллыг баримтлана. Үүнд:

А. Бэлтгэл ажил:

- ✓ Зураг төсөл, техникийн шаардлага болон бусад холбогдох баримт бичигтэй (тайлбар бичиг, геологи, геодези, байгаль орчны тайлан гэх мэт) танилцаж, ажлын тоо хэмжээг нягтлан шалгах;
- ✓ Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй жишиг үнэ, тариф, норм, норматив, эрх зүйн баримт бичиг болон холбогдох суурь нормыг бүрдүүлэх;
- ✓ Суурь нормын ажлын нэр төрөл, хэмжих нэгжид тохируулан ажлын тоо хэмжээ, суурь нормын үндэслэлийг тодорхойлох;
- ✓ Суурь нормд байхгүй ажилбарын үнэлгээг ижил төстэй ажлаар орлуулах, эсвэл шаардлагатай тохиолдолд шинээр тооцоолох;
- ✓ Суурь норм болон төсөвт өртөг тооцох нормд заасан итгэлцүүрүүдийг ямар ажилд, ямар онцлог нөхцөлд ашиглахыг тогтоож, баримт бичгийг бүрдүүлэх;
- ✓ Төсөвт өртөг тооцоход ашиглах үнэ бүрдлийн талаарх төрийн захиргааны байгууллагын шийдвэр, тогтоол, дүрэм журам, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэх;

Б. Төсвийн тооцооны дараалал:

- ✓ Ажилтны хөдөлмөр зарцуулалтын тооцоо
- ✓ Нийт цалин, ЭМ, НД-ын шимтгэлийн зардлын тооцоо
- ✓ Машин механизмын операторын цалингийн зардлын тооцоо
- ✓ Тээврийн жолоочийн цалингийн зардлын тооцоо
- ✓ Нэмэгдэл цалингийн зардлын тооцоо
- ✓ Инженер техникийн ажилтны (ИТА) цалингийн зардлын тооцоо
- ✓ Алслалтын нэмэгдэл цалингийн зардлын тооцоо
- ✓ Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл
- ✓ Материалын зардлын тооцоо
- ✓ Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын тооцоо
- ✓ Материалын тээврийн зардлын тооцоо
- ✓ Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардлын тооцоо
- ✓ Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардлын тооцоо
- ✓ Шууд зардлын тооцоо
- ✓ Удирдлага, зохион байгуулалтын зардлын тооцоо
- ✓ Ашгийн зардлын тооцоо
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлын тооцоо
- ✓ Даатгалын зардлын тооцоо
- ✓ Барилга угсралтын ажлын зардлын тооцоо

- ✓ Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлын тооцоо
- ✓ Магадалшгүй ажлын зардал
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татварын зардлын тооцоо
- ✓ Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал
- ✓ Захиалагчийн хяналтын зардал
- ✓ Авто замын норм, нормативын сангийн шимтгэл
- ✓ Бусад зардлын тооцоо
- ✓ Нэгдсэн төсвийн тооцоо
- ✓ Хөрөнгө оруулалтын зардлын тооцоо

В. Төсвийн тооцоог гүйцэтгэх:

- ✓ Объектын (шууд зардал) төсвийн тооцоо
- ✓ Барилга угсралтын ажлын төсвийн тооцоо
- ✓ Нэгдсэн төсвийн тооцоо
- ✓ Хөрөнгө оруулалтын зардлын тооцоо
- ✓ Нэгж үнэ ба нийт үнийн тооцоо хийх гэх мэт дарааллаар төсвийн баримт бичгийг бүрдүүлнэ.

3. ОБЪЕКТЫН ТӨСВИЙН ТООЦОО

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

3.1.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэхэд төслийн талбай дээр гарч буй шууд зардлыг ашиглан объектын төсвийн тооцоог боловсруулна.

3.1.2. Объектын төсөв нь анхан шатны үйлдвэрлэлийн нэгж, байгууллагын баримт бичиг бөгөөд ерөнхий болон туслан гүйцэтгэгч байгууллагын хийх ажлын хэмжээг тодорхойлоход ашиглана.

3.1.3. Төсөвт өртгийг ажлын зураг төсөлд тусгасан тоо хэмжээ, техникийн шаардлага болон технологийн дарааллыг үндэслэн, төсвийн тооцооны бүлэг тус бүрээр гаргана.

3.1.4. Төсвийн нормын бүлгүүд нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

А. Авто замын барилгын ажил

- а) Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил
- б) Замын трасс сэргээж, гадаслах
- в) Материалын шинжилгээ, туршилтын ажил
- г) Замын трасс, талбайн цэвэрлэгээний ажил

- д) Карьер, шороон орд нээх, нөхөн сэргээх ажил
- е) Түр болон туслах замын ажил
- ё) Замын далан, ухмалын ажил
- ж) Замын суурийн ажил
- з) Замын хашлага байрлуулах ажил
- и) Замын хучилтын ажил
- й) Замын хайрган хөвөө байгуулах ажил
- к) Ус зайлуулах энгийн байгууламжийн ажил
- л) Явган хүн ба унадаг дугуйн замын ажил
- м) Замын тэмдэглэгээний ажил
- н) Замын тоноглолын ажил
- о) Замын тохижилтын ажил
- е) Өрөмдлөгө, тэсэлгээний ажил
- п) Материал бэлтгэх ажил
- р) Хог хаягдал цэвэрлэх
- с) Авто зам, замын байгууламжийг улсын ашиглалтад оруулах
- т) Хүйтний улиралд хийгдэх замын ажил
- у) Бусад ажил
- ф) Үйлдвэр, заводыг ачиж буулгах, угсрах, хураах ажил
- х) Замын бүх ажлууд

Б. Төмөрбетон гүүр, хоолой, хиймэл байгууламжийн ажил

- а) Барилгын талбайн бэлтгэл
- б) Гүүр, хоолойн материалын ба хийц бүтээцийн үйлдвэрлэлийн бэлтгэл ажил
- в) Гүүрийн тулгуурын энгийн суурь
- г) Өрөмдмөл баганат суурь байгуулах
- д) Захын болон завсрын тулгуур байгуулах
- е) Алгаслалын бүтээц байрлуулах ба байгуулах
- ё) Зорчих хэсэг байгуулах
- ж) Хэв гажилтын заадас байгуулах

- з) Урсгал залах далан байгуулах
- и) Далан сувгийн бэхэлгээ
- й) Төмөр бетон хоолойн барилга
- к) Арматур хүчитгэх
- л) Лабораторийн туршилт, шинжилгээ
- м) Объектыг ашиглалтад оруулах

В. Арчлалт, засварын ажил

- а) Шороон далан, суурь хөвөө ба шуудууны арчлалт, засварын ажил
- б) Авто замын шороон далан, хучилтын өргөтгөлийн ажил
- в) Хучилтгүй зам болон хөнгөвчилсөн шилжилтийн төрлийн хучилтын арчлалт, засварын ажил
- г) Хучилттай авто замын арчлалт, засварын ажил
- д) Тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолын арчлалт, засварын ажил
- е) Модон гүүрийн арчлалт, засварын ажил
- ё) Ус өнгөрүүлэх хоолойн арчлалт, засварын ажил
- ж) Төмөрбетон гүүрийн арчлалт, засварын ажил
- з) Өвлийн арчлалт, засварын ажил
- и) Бусад ажил

3.1.5. Шууд зардлыг тодорхойлохдоо дараах үндсэн өгөгдлүүдийг ашиглана. Үүнд:

- а. Ажилтны хөдөлмөр зарцуулалт (хүн/цаг)
- б. Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл, ажиллах цаг (маш/цаг)
- в. Материал ба хийц эдлэлийн зарцуулалт (m^3 , m^2 , тн, у/м, кг, ширхэг гэх мэт)
- г. Материал, хийц эдлэлийн тээвэрлэлт (тн/км)
- д. Түр барилгын элэгдлийн хугацаа (жил, сар)

3.1.6. Объектын (шууд зардлын) төсөвт дараах зардлуудыг тооцно. Үүнд:

- ✓ Нийт цалин,
- ✓ Материалын зардал,
- ✓ Тээврийн зардал,
- ✓ Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал,

- ✓ Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл,
- ✓ Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардал,
- ✓ Ажилтнуудад үйлчлэх зардал,

3.1.7. Төсвийн бүрдэл хэсгүүдийн тооцоог боловсруулсны дараа нэгтгэн тухайн объектын төсвийг тооцно. Энэхүү тооцоо нь зам барилгын тодорхой ажил, эсвэл ажлын бүлгийн өртгийг харуулна.

3.1.8. Шууд зардлыг үндэслэн боловсруулсан объектын төсөв нь талбайн инженер техникийн ажилтнуудын тооцоо, төлөвлөлтийн үндсэн гарын авлага болно.

3.2. АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨР ЗАРЦУУЛАЛТ, НИЙТ ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.2.1. Зураг төсөлд тусгагдсан ажлын тоо хэмжээг төсвийн суурь нормоор тогтоосон нэгж ажлын хөдөлмөр зарцуулалтаар үржүүлж, ажилтны нийт хөдөлмөр зарцуулалтыг тооцно. Ажилтны хөдөлмөр зарцуулалтын тооцоог Маягт №1А-н дагуу гүйцэтгэнэ.

3.2.2. Төсвийн суурь нормоор тооцсон ажилтны хөдөлмөр зарцуулалтыг Хавсралт №2-д заасан ажилтны цагийн тарифт цалингийн жишгээр үржүүлж, үндсэн цалинг тодорхойлно. (Маягт №1Б)

3.2.3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын хавсралтаар батлагдсан “Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөл”-д хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг үндэслэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтанд олгох нэмэгдлийн хувийг Авто замын салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрээр тогтоож, Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. (Хавсралт №2).

3.2.4. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчдад олгох нэмэгдлийг батлагдсан хувь хэмжээний дагуу ажилтны үндсэн цалингаас тооцно. Авто замын салбарын хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтны ажил, мэргэжлийн жагсаалтыг Хавсралт №6-д тусгав.

3.2.5. Машин механизмын операторын цалинг машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын нийт дүнгийн 8.7 хувиар, тээврийн жолоочийн цалинг тээврийн зардлын нийт дүнгийн 8.7 хувиар тооцно.

3.2.6. Ажилтны нэмэгдэл цалинг үндсэн цалингаас 30 хувиар, тээврийн жолооч, машин механизмын операторын нэмэгдэл цалинг эдгээр ажилтны үндсэн цалингийн нийлбэр дүнгийн 30 хувиар тус тус тооцно. Нэмэгдэл цалинд нэмэгдэл хөлс болон ээлжийн амралт, сул зогсолтын үеийн цалин хамаарна.

3.2.7. Инженер техникийн ажилтны цалинг ажилтны үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторын цалингийн нийлбэр дүнгийн 25 хувиар тооцно.

3.2.8. Инженер техникийн ажилтны цалин нь үндсэн цалин, нэмэгдэл цалин, нэмэгдэл хөлс, ээлжийн амралт, сул зогсолтын үеийн цалингаас бүрдэнэ.

3.2.9. “Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын хугацааны норматив, гүйцэтгэгчээс талбайд ажиллах ИТА-ны тоо, үе шатны ажилд зарцуулах цагийн норм”-ыг үндэслэн инженер техникийн ажилтны зэрэглэл, цалингийн итгэлцүүрийг ашиглан ИТА-ны цалингийн нормативыг тогтооно. (Хавсралт №14)

3.2.10. Улсын нийслэлээс алслагдсан бүс нутагт авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил гүйцэтгэх тохиолдолд ажилтнуудад алслалтын нэмэгдэл цалин тооцно.

3.2.11. Ажилтны алслалтын нэмэгдэл цалинг үндсэн цалингаас Хүснэгт №1-д заасны дагуу тооцно.

3.2.12. Тээврийн жолооч, машин механизмын оператор, инженер техникийн ажилтны цалингийн нийлбэр дүнгээс Хүснэгт №1-д заасны дагуу алслалтын нэмэгдэл цалинг тооцно.

3.2.13. Ажил гүйцэтгэх объектын алслагдсан зайн тооцооллыг төсөвт Улаанбаатар хотоос тухайн бүс нутаг руу нүүлгэн ажиллуулахаар тусгана.

Хүснэгт №1

№	Тойргийн хүрээ	Улаанбаатар хотоос алслагдсан тойргийн хэмжээ, км-ээр	Цалинг нэмэгдүүлэх хэмжээ (хувиар)
1	I	300-600	10
2	II	601 – 1000	15
3	III	1001 – ээс дээш	20

3.2.14. Ажилтны бүгд цалин, тээврийн жолооч, машин механизмын операторын цалин, инженер техникийн ажилтны цалин, нэмэгдэл цалин, алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэрээр нийт цалингийн хэмжээг тодорхойлно.

3.2.15. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл цалин, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн зардлыг “Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт” болон “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг төлөх ажил мэргэжлийн жагсаалт”-ыг үндэслэн, Маягт №1Б, Хавсралт №6-д заасны дагуу тооцно.

3.2.16. “Авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг тооцоход хэрэглэх ажилтны цагийн тарифт цалингийн жишиг”-ийг цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг үндэслэн, инфляцийн түвшин болон салбарын хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй уялдуулан тогтооно.

3.2.17. Ажилтны цагийн тарифт цалинг шинэчлэх асуудлыг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, ажил олгогч, ажилтны эрх ашгийг хамгаалах байгууллагуудын хамт /тариф/-ын хэлэлцээрээр шийдвэрлэнэ.

3.2.18. Хамтын хэлэлцээрт тусгагдсан “Авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг тооцоход хэрэглэх ажилтны цагийн тарифт цалингийн жишиг”-ийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, төсөвт өртгийн тооцоонд дагаж мөрдөнө.

3.3. МАТЕРИАЛ БОЛОН ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.3.1. Материалын зардлын тооцоо нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардагдах материалын нийт хэрэгцээ болон өртгийг тодорхойлох үйл явц юм.

3.3.2. Төсвийн суурь нормын материалын орц норм болон зах зээлийн жишиг үнэд тулгуурлан авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардагдах материалын зардлыг тооцно.

3.3.3. Төсвийн суурь нормд тухайн ажилд шаардагдах материал, хийц бүтээцийн нэр төрөл, хэмжих нэгж болон нэгж хүндийг тусгасан байна.

3.3.4. Материалын нийт хэрэгцээг тодорхойлоход төсвийн суурь нормын нэгж орцыг ажлын тоо хэмжээ, хаягдал, хорогдол болон сийрэгжилтийн итгэлцүүрээр үржүүлнэ.

3.3.5. Материалын нийт хэрэгцээ, зээлийн жишиг үнэд тулгуурлан материалын зардлыг Маягт №2А, Маягт №2Б-д заасан аргачлалаар тооцно.

3.3.6. Төсвийн суурь нормд бетоны арматурыг дундаж (орц) хэмжээгээр тооцсон байдаг учраас зураг төсөлтэй уялдуулан тооцно. Төсвийн нормд тусгагдаагүй материал ашиглахаар зураг төсөлд тусгагдсан тохиолдолд тухайн материалын шинж чанарыг судлан, орц болон жинг зөв тогтоож төсөвт тусгана.

3.3.7. Материалын зардлыг тухайн объектын ажлын зураг, техникийн шаардлага, ажлын тоо хэмжээг үндэслэн, материал, хийц, эдлэхүүний (тн, м², м³, у/м, кг, ширхэг гэх мэт) шаардлагатай тоо хэмжээ болон материалын төрөл тус бүрт харгалзах зах зээлийн жишиг үнийг ашиглан тооцно.

3.3.8. Материалын зардлын тооцоонд нэмэгдсэн өртгийн албан татварыг (НӨАТ) оруулахгүй.

3.3.9. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд хэрэглэх аливаа материалын үнийг ажил гүйцэтгэж буй бүс нутгийн зах зээлийн үнээр авч төсвийн тооцоонд тусгана.

3.3.10. Материал, хийц, эдлэхүүний үнэ бүрдэлт дараах нийтлэг жишигтэй байна. Үүнд:

а) Импортын бараа материал

Өртгийн бүрэлдэхүүн хэсгүүд

- ✓ Барааны худалдан авах үнэ - үйлдвэрлэгч эсвэл борлуулагчид төлөх дүн. Сонгосон худалдааны гэрээний нөхцөлөөс (*Incoterms**) шалтгаалан зарим зардал багтаж болно.
- ✓ Нийлүүлэгч улсын ложистикийн үйлчилгээ - чанарын шалгалт, нийлүүлэгчийн агуулахаас илгээх цэг хүртэлх (боомт, төмөр замын терминал, нисэх буудал гэх мэт) тээвэрлэлт, экспортын гаалийн бүрдүүлэлт.
- ✓ Монгол Улсын хил хүртэлх тээвэрлэлтийн зардал.
- ✓ Монгол Улсын ложистикийн үйлчилгээ - терминалын агуулахын боловсруулалт, импортын гаалийн бүрдүүлэлт, хүлээн авагчийн агуулах хүртэлх хүргэлт.
- ✓ Гаалийн төлбөрүүд - импортын татвар, НӨАТ.

*Incoterms** - (Олон улсын худалдааны нөхцөлүүд) нь экспорт, импортын гэрээнд барааны тээвэрлэлтийн үеийн хариуцлага, эрсдэл, зардлыг хэн хариуцахыг тодорхойлдог олон улсын стандарт нөхцөлүүд юм. Импортын материалын үнийг дээрх бүрэлдэхүүн хэсгүүдийг ашиглан Хавсралт №15-д заасан аргачлалаар урьдчилан тооцно.

б) Эх орны үйлдвэрийн материал

Эх орны үйлдвэрийн материалын үнэ дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$Y_{\text{эх орон}} = \text{БҮ} + \text{НӨАТ} + \text{ББ} + \text{БЗ}$$

- ✓ БҮ- үйлдвэрийн үнэ;
- ✓ НӨАТ- нэмэгдсэн өртгийн албан татвар;
- ✓ ББ - баримтын үнэ (падаан зэрэг нягтлангийн зардал),
- ✓ БЗ - буулгах зардал.

Эх орны материалыг агуулахаар дамжуулахгүйгээр шууд объект дээр буулгана гэж тооцно.

в) Гүйцэтгэгч байгууллагын өөрөө бэлтгэх материал

Гүйцэтгэгч байгууллага өөрийн үйлдвэрлэлийн баазыг ашиглан зам барилгын материал үйлдвэрлэхдээ дараах зардлуудыг тооцно.

- ✓ Түүхий эд, материал,
- ✓ Тоног төхөөрөмж худалдан авалт, ашиглалт, засвар үйлчилгээ хийх,
- ✓ Ажилчдын цалин хөлс
- ✓ Урсгал зардал
- ✓ Элэгдлийн зардал гэх мэт.

Дээрх бүх зардлыг нэмж, үйлдвэрлэлийн нийт өртгийг тодорхойлно. Үүнийг дараах томъёогоор илэрхийлнэ.

Томъёо: **C = M + З + А + П**

- ✓ **C** – үйлдвэрлэлийн өртөг
- ✓ **M** – материал
- ✓ **З** – үйлдвэрлэлийн болон туслах ажилчдын цалин
- ✓ **A** – барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл
- ✓ **П** – урсгал зардал

Үйлдвэрлэлийн зардлын бүх бүрэлдэхүүн хэсэг, бүтээгдэхүүний өртгийг зөв тодорхойлсны үндсэн дээр материалын үнийг төсвийн тооцоонд тусгана.

3.3.11. Материалын тээврийн зардлын тооцоог Маягт №3А, Маягт №3Б-н дагуу тооцно.

3.3.12. Төсвийн суурь нормоор тодорхойлсон материал, эдлэл, хийц бүтээцийн норматив хэрэгцээг нэр төрлөөр нь нэгтгэн, тээврийн зардлын тооцоонд тусгана.

3.3.13. Материалын зардлын тооцоогоор гарсан нийт хэрэгцээт хэмжээг материал тус бүрийн нэгж жингээр үржүүлж, нийт жинг тодорхойлно.

3.3.14. Тээврийн зардлын тооцоо нь материал тус бүрийг тээвэрлэхэд гарах зардлыг нарийвчлан тооцож, нийт зардлыг нэгтгэн гаргах үйл явц юм.

3.3.15. Материал, хийц эдлэл, бүтээцийг тээвэрлэх зай болон ачааны зэргийг тогтоон, автомашинаар ачаа тээвэрлэх тн/км-ын жишиг тарифаар үржүүлж тээврийн зардлыг тооцно.

3.3.16. Төсвийн тооцоог хялбарчлах зорилгоор материалыг дараах байдлаар бүлэглэн тооцож болно. Үүнд:

- ✓ Үйлдвэрээс тээвэрлэх материал,
- ✓ Шороон ордоос тээвэрлэх материал,
- ✓ Улаанбаатар хотоос тээвэрлэх материал,

- ✓ Аймаг, сумын төвөөс тээвэрлэх материал,
- ✓ Хилийн боомтоос тээвэрлэх материал гэх мэт

3.3.17. Ачааны зэргийг зарим тохиолдолд дараах байдлаар хялбарчилсан байдлаар ангилан тооцож болно. Үүнд:

а) Тээврийн хэрэгслийн даацад бүрэн ачигдах, эвдрэл гэмтэлд мэдрэмтгий бус ачаа- I зэрэг

б) Тээврийн хэрэгслийн даацад бүрэн ачигдах боломжгүй, хагарч гэмтэх магадлалтай ачаа - II зэрэг

в) Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл шаарддаг, овор ихтэй эсвэл аюултай ачаа - III зэрэг

3.3.18. Ачааны зэрэг, тээврийн зайнаас хамааруулан автомашинаар ачаа тээвэрлэх 1 тн/км-ын жишиг тарифыг Хавсралт №4-1, №4-2- заасан хүснэгтээс сонгоно.

3.3.19. Тээврийн жолоочийн цалингийн зардлыг тээврийн зардлын тооцооны нийт дүнгийн 8.7 хувиар тооцно.

3.3.20. Тооцсон цалинг нийт цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын тооцооны “Тээврийн жолоочийн цалин” мөрөнд тусгана.

3.3.21. Нэгдсэн төсвийн тооцоонд тээврийн зардлыг тээврийн жолоочийн цалин хассан дүнгээр тусгана.

3.4. МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

3.4.1. Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг төсвийн суурь нормд заасан машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл, ажиллах хугацаа, нэг машин цагийн жишиг үнэд тулгуурлан тодорхойлно.

3.4.2. Төсвийн суурь нормд тухайн ажилд шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл, машин цагийн хэмжээг тусгасан байна.

3.4.3. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг Маягт №4А, Маягт №4Б-н дагуу тооцно.

3.4.4. Машин механизмын операторын цалингийн зардлыг машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын тооцооны нийт дүнгийн 8.7 хувиар тооцно.

3.4.5. Тооцсон цалинг нийт цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын тооцооны “Машин механизмын операторын цалин” мөрөнд тусгана.

3.4.6. Нэгдсэн төсвийн тооцоонд машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг операторын цалин хассан дүнгээр тусгана.

3.4.7. Төсөвт өртгийн тооцоонд машин механизм, тоног төхөөрөмжийн нэг машин цагийн жишиг үнийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын нэг машин цагийн жишиг үнэ”-ийг баримтлана. (Хавсралт №3)

3.4.8. Хэрэв тухайн машин механизм, тоног төхөөрөмжийн нэг машин цагийн батлагдсан жишиг үнэ байхгүй тохиолдолд хүчин чадал, техникийн үзүүлэлт нь ойролцоо машин механизм, тоног төхөөрөмжийн жишиг үнийг ашиглан үнэлнэ.

3.4.9. Гүйцэтгэгч байгууллага машин механизм, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, хүчин чадал, өөрийн өртөг, ашиглалтын зардлын талаарх мэдээллийг тогтмол бүртгэн хадгалж, шаардлагатай үед шинэчлэн оруулна.

3.4.10. Машин механизм, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт болон ашиглалтын талаарх мэдээллийг холбогдох байгууллагууд нэгтгэн бүртгэж, суурь норм боловсруулах, машин цагийн жишиг үнэ тогтоох, өртгийн тооцооны үйл ажиллагаанд ашиглана.

3.4.11. Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажилтны цалингийн зардлыг нэг машин цагийн жишиг багтаан тооцно.

3.5. ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.5.1. Монгол Улсын “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэж заасан. (Хүснэгт №2)

Хүснэгт №2

№	Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар)	Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар)
1	Тэтгэврийн даатгал	8.5	8.5

2	Тэтгэмжийн даатгал	1.0	0.8
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.5, 1.5, 2.5	-
4	Ажилгүйдлийн даатгал	0.5	0.2
	Шимтгэлийн дүн	10.5, 11.5, 12.5	9.5

3.5.2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Жагсаалт, журам батлах тухай” 471 дүгээр тогтоолын Хавсралт №1, Хавсралт №2-т заасны дагуу тооцно.

3.5.3. Ажилтны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажилтны үндсэн цалин, нэмэгдэл цалин, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл болон алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэрээс тооцно.

3.5.4. Ажилтны тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилтны үндсэн цалин, нэмэгдэл цалин, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл болон алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэрээс 10 хувиар тооцно.

3.5.5. Машин механизмын оператор, тээврийн жолооч, инженер техникийн ажилтны үндсэн цалин, нэмэгдэл цалин, алслалтын нэмэгдэл цалин тус бүрээс үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 2.5 хувиар, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 10 хувиар тооцно.

3.5.8. Монгол Улсын “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар жил бүр”, 8.2.1-д “Шимтгэлийг даатгуулагч, ажил олгогч тэнцүү хувь хэмжээгээр сар бүр төлнө” гэж тус тус заасан.

3.5.9. Ажилтны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ажилтны үндсэн цалин, нэмэгдэл цалин, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл болон алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэрээс 2 хувиар тооцно.

3.5.10. Машин механизмын оператор, тээврийн жолооч, инженер техникийн ажилтны үндсэн цалин, нэмэгдэл цалин, алслалтын нэмэгдэл цалин тус бүрээс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 2 хувиар тооцно.

3.5.11. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг төсөвт өртөг тооцох нормын Хавсралт №6, Хавсралт №14, Маягт №1Б-д заасны дагуу тооцно.

3.5.12. Монгол Улсын “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”, “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль” болон холбогдох ажил, мэргэжлийн жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд тухайн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3.6. АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЭЛЭГДЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.6.1. Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардал нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтын явцад үүсэх элэгдэл, хорогдлын өртгийг илэрхийлнэ. (Хавсралт №16)

3.6.2. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд дараах төрлийн багаж, тоног төхөөрөмжийг ашиглана. Үүнд:

1. Лабораторийн багаж тоног төхөөрөмж (прокторын хэв, алх, индикатор гэх мэт)
2. Гар багаж, тоног төхөөрөмж (хүрз, лоом, алх, метр гэх мэт)
3. Геодезийн хэмжилтийн багаж, төхөөрөмж (теодолит, нивелир, GPS гэх мэт)
4. Бусад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж

3.6.3. Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардлыг ажилтны үндсэн цалингийн дүнгээс 5 хувиар тооцож, төсөвт тусгана.

3.7. АЖЛЫН ТАЛБАЙД АЖИЛЛАХ АЖИЛТНУУДАД ҮЙЛЧЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

3.7.1. Хот, төв суурин газар болон хөдөө орон нутагт ажиллах инженер техникийн ажилтан (ИТА), замчин, машин механизмын оператор, жолооч, үйлчилгээний ажилтанд ажилласан нэг хүн/өдөр тутамд 16000 төгрөгийн "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ыг тооцож, төсөвт тусгана.

3.7.2. Нэгдсэн төсвийн тооцоонд "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын хэмжээг дараах хөдөлмөр зарцуулалтын үзүүлэлтэд үндэслэн тодорхойлно. Үүнд:

- ✓ Ажилтны хөдөлмөр зарцуулалтын нийт хэмжээ (хүн/цаг),
- ✓ Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын нийт машин цаг (маш/цаг),
- ✓ Тээврийн зардлын тооцооны тээврийн нийт хөдөлмөр зарцуулалт (хүн/цаг),

3.7.3. "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын нийт хэмжээг дараах байдлаар тооцно. Үүнд: Ажилтны хөдөлмөр зарцуулалтын нийт хэмжээ (хүн/цаг), машин механизм, тоног төхөөрөмжийн нийт машин цаг (маш/цаг), тээврийн зардлын тооцооны нийт хөдөлмөр зарцуулалтын нийлбэрийг ажлын нэг өдрийн үргэлжлэх хугацаа (8)-д хувааж, нэг хүн/өдрийн 16000 төгрөгийн нормативт зардлаар үржүүлж тооцно.

3.7.4. Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлын тооцоонд "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ыг дараах хөдөлмөр зарцуулалтын үзүүлэлтэд үндэслэн тодорхойлно. Үүнд:

- ✓ Нүүлгэн шилжүүлэх зардлын тээврийн хөдөлмөр зарцуулалт,
- ✓ Инженер техникийн ажилтнуудын нийт хөдөлмөр зарцуулалт,
- ✓ Өөрөө явагч тээврийн хэрэгслийн нүүлгэн шилжүүлэх ажлын жолоочийн хөдөлмөр зарцуулалт,
- ✓ Үйлчилгээний ажилтнуудын нийт хөдөлмөр зарцуулалт,
- ✓ Харуул хамгаалалтын ажилтны нийт хөдөлмөр зарцуулалт,

3.7.5. Инженер техникийн ажилтан, харуул болон үйлчилгээний ажилтнуудын хөдөлмөр зарцуулалтыг "Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын хугацааны норматив, гүйцэтгэгчээс талбайд ажиллах ИТА-ны тоо, үе шатны ажилд зарцуулах цагийн норм"-ыг үндэслэн тодорхойлно.

3.7.6. Тээвэр, нүүлгэн шилжүүлэх ажлын хөдөлмөр зарцуулалтыг (хүн/цаг) дараах томъёогоор тооцно.

$$T_{\text{хц}} = \left[\frac{A_{\text{ж}} \times X_{\text{з}}}{Q_{\text{б}}} \right] : U_{\text{д}} \times 1.2$$

$T_{\text{хц}}$ – тээврийн хөдөлмөр зарцуулалт (хүн/цаг),

$A_{\text{ж}}$ - тухайн материалын нийт жин (тн),

$X_{\text{з}}$ - тээврийн зай (км),

$Q_{\text{б}}$ – тээврийн хэрэгслийн даац (тн),

$U_{\text{д}}$ - дундаж хурд (км/цаг),

1.2 - цагийн алдагдлыг тооцсон коэф,

3.7.7. Материалын тээвэр, нүүлгэн шилжүүлэх ажилд дараах техникийн үзүүлэлтийг мөрдөнө. Үүнд:

- ✓ Технологийн тээврийн машин: даац 15 тн, дундаж хурд 20 км/ц,
- ✓ Холын тээврийн машин: даац 25 тн, дундаж хурд 60 км/ц,

Тайлбар:

Технологийн тээвэр нь төслийн талбай дотор болон ойр орчимд материалыг нэг цэгээс нөгөө цэгт зөөвөрлөх үйл ажиллагаа юм.

Холын тээвэр нь алслагдсан эх үүсвэрээс их хэмжээний материалыг төвлөрсөн байршилд тээвэрлэх үйл ажиллагаа болно.

3.7.8. Өөрөө явагч тээврийн хэрэгслийн нүүлгэн шилжүүлэх үеийн жолоочийн хөдөлмөр зарцуулалтыг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$MD = \frac{L}{Z}$$

MD - Жолоочийн хөдөлмөр зарцуулалт (хоног),

L - Тээврийн зай (км),

Z - Тээврийн хэрэгслийн хоногийн дундаж гүйлт (400 км/хоног),

3.7.9. Технологийн тээвэр болон холын тээвэрт хамаарах материалын жагсаалтыг нормын Хавсралт №12-т заасан. Нүүлгэн шилжүүлэх машин механизм, тоног төхөөрөмж холын тээвэрт хамаарна.

3.7.10. Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлын тооцооны "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын хэмжээг нүүлгэн шилжүүлэх зардлын тээврийн хөдөлмөр зарцуулалт, өөрөө явагч тээврийн хэрэгслийн жолоочийн хөдөлмөр зарцуулалт, инженер техникийн ажилтан, харуул болон үйлчилгээний ажилтнуудын нийт хөдөлмөр зарцуулалтын нийлбэрийг ажлын нэг өдрийн үргэлжлэх хугацаа (8)-д хувааж, нэг хүн/өдрийн 16000 төгрөгийн нормативт зардлаар үржүүлж тооцно.

3.8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛ, ТҮР БАРИЛГЫН ЭЛЭГДЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.8.1 Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлыг нэгдсэн төсвийн тооцооны "Бусад зардал" бүлэгт тусгана. Уг зардлыг аж ахуйн нэгжийн орлогод нэмж бүртгэх бөгөөд татвар ногдуулах орлогод хамаарна.

3.8.2. Нэгж жин нь 1 тонноос дээш жинтэй машин механизм, тоног төхөөрөмжийг объектод хүргэх, ажил дууссаны дараа буцаан тээвэрлэх зардлыг тээврийн ирэх, буцах нийт тээврийн зайд үндэслэн тооцож, төсөвт тусгана.

3.8.3. Нүүлгэн шилжүүлэх машин механизм, тоног төхөөрөмж, түр барилга, үйлдвэр, заводын тоо хэмжээг жилд ажиллах машин цаг болон авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын хугацааны нормативт үндэслэн үнэн зөв тодорхойно.

3.8.4. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын хугацаанд талбайд ажиллах инженер техникийн болон бусад ажилтныг ажил эхлэх ба дуусах, ээлж

солигдох, баяр ёслол, амралтын үед төслийн талбайд хүргэх, буцаан тээвэрлэхтэй холбогдон гарах зардлыг “Ажилтныг тээвэрлэх зардал” гэж тодорхойлно. Уг зардалд ажилтны ирэх, буцах тээврийн зардлыг бүрэн хамруулна.

3.8.5. Ажилтныг тээвэрлэх зардлыг дараах үзүүлэлтэд үндэслэн тооцно. Үүнд:

- ✓ Ажилтны тоо;
- ✓ Ээлжийн тоо;
- ✓ Тээвэрлэх зай (ирэх, буцах);
- ✓ Нэг хүн/км-ийн тариф.

3.8.6. Ажлын талбай, замын трассын дагуух машин механизм, тоног төхөөрөмжийг шилжүүлэхтэй холбогдох зардал нь тухайн машин механизм, тоног төхөөрөмжийн нэгж машин цагийн үнэд багтсан тул төсөвт тооцохгүй.

3.8.7. Нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн зардлыг нүүлгэн шилжүүлэх ажлын нийт зардлын дүнгийн 8.7 хувиар тооцож, төсөвт тусгана.

3.8.8. Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлын тооцоонд нүүлгэн шилжүүлэх зардлыг тусгахдаа цалингийн зардлыг хассан дүнгээр тооцно.

3.8.9. Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд ачих шаардлагагүй, өөрөө явагч тээврийн хэрэгслийн нүүлгэн шилжүүлэх зардлыг төсөвт тусгана. Өөрөө явагч тээврийн хэрэгслийн нүүлгэн шилжүүлэх үеийн жолоочийн цалинг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$DP = \frac{L \times 8 \times T_p}{Z}$$

DP - Жолоочийн цалин,

L - Тээврийн зай (км),

Z - Тээврийн хэрэгслийн хоногийн дундаж гүйлт (400 км/хоног),

T_p - VI зэргийн ажилтны цагийн тарифт цалин,

3.8.10. Өөрөө явагч тээврийн хэрэгслийн нүүлгэн шилжүүлэх үеийн шатахуун зарцуулалтыг эрх бүхий байгууллагын баталсан шатахууны норм болон Хавсралт №10-д заасны дагуу тооцно.

3.8.11. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын явцад түр хугацаанд ашиглах барилга, байгууламжийн элэгдэл, хорогдлын зардлыг төсөвт тооцно. Үүнд:

- ✓ Оффис, лабораторийн байр,
- ✓ Ажилтнуудын түр байр, хоолны газар, халуун усны байр,
- ✓ Агуулах, склад,
- ✓ Цахилгаан хангамжийн шугам сүлжээ,
- ✓ Хашаа, хамгаалалтын байгууламж зэрэг орно.

3.8.12. Түр барилгын элэгдлийн зардлыг ажлын зураг, тоо хэмжээ, техникийн шаардлага, холбогдох хууль, журам болон авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын хугацааны нормативт үндэслэн тусад нь тооцож, нүүлгэн шилжүүлэх ажил болон түр барилгын элэгдлийн зардлын тооцоонд тусгана.

3.8.13. Түр барилгын элэгдэл тооцох үнийг тухайн бүс нутгийн зах зээлийн дундаж үнэд тулгуурлан тодорхойлно.

3.8.14. Дансны үнэ, овор хэмжээний хувьд ижил төстэй түр барилга, байгууламжид ижил элэгдлийн зардлыг ижил элэгдлийн хувь хэмжээг хэрэглэнэ.

3.8.15. Түр барилгын элэгдлийн тооцоог хийхдээ дараах зарчмыг баримтлана. Үүнд:

а) Нэг удаагийн хэрэглээтэй, дахин ашиглах боломжгүй түр барилгад элэгдлийн зардал тооцохгүй.

б) Дахин ашиглах боломжтой түр барилгад ашиглалтын норм, балансын үнэ, элэгдлийн хувийг тогтоож тооцно.

в) Нэг буюу түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгийн элэгдэл, хорогдлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцно.

г) Түр барилгын элэгдлийн тооцоог Маягт №7Г-ийн дагуу хийж, нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлын нэгдсэн төсвийн тооцоонд тусгана.

3.8.16. “Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардал”-ыг тусад нь тооцож, нэгдсэн төсвийн тооцооны “Бусад зардал” бүлэгт нэгтгэн тусгана.

3.8.17. “Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардал” нь дараах зардлаас бүрдэнэ. Үүнд:

- ✓ Нүүлгэн шилжүүлэх ажлын цалин
- ✓ Өөрөө явагч тээврийн хэрэгслийн жолоочийн цалин
- ✓ Нэмэгдэл цалин
- ✓ Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл
- ✓ Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал
- ✓ Нүүлгэн шилжүүлэх ажлын зардал
- ✓ Өөрөө явагч тээврийн хэрэгслийн нүүлгэн шилжүүлэх ажлын зардал
- ✓ Ажилтныг тээвэрлэх зардал

- ✓ Түр барилгын элэгдлийн зардал
- ✓ Удирдлага, зохион байгуулалтын зардал
- ✓ Ашгийн зардал
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал
- ✓ Даатгалын зардал
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)

4. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨСВИЙН ТООЦОО

4.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

4.1.1. Энэхүү төсвийн тооцоо нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэгч байгууллагын барилга угсралтын ажлын төсөвт өртгийг тодорхойлоход хэрэглэнэ.

4.1.2. Барилга угсралтын ажлын төсөв нь дараах зардлаас бүрдэнэ. Үүнд:

- ✓ Объектын төсвөөр тодорхойлогдсон шууд зардал,
- ✓ Удирдлага, зохион байгуулалтын зардал,
- ✓ Ашгийн зардал,
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал,
- ✓ Даатгалын зардал

4.1.3. Барилга угсралтын ажлын төсвийн тооцоог Маягт №6-н дагуу тооцно.

4.1.4. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг үндсэн барилга угсралтын ажил болон нүүлгэн шилжүүлэлт, түр барилгатай холбоотой барилга угсралтын ажил гэж ангилна. Үүнд:

- ✓ Үндсэн барилга угсралтын ажил - авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын технологийн үндсэн ажлууд,
- ✓ Нүүлгэн шилжүүлэлт, түр барилгатай холбоотой барилга угсралтын ажил - төслийн хэрэгжилтийн явцад шаардлагатай нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилга байгууламж барих, угсрах зэрэг ажлууд,

4.1.5. Дээрх зардлын нийлбэрийг Барилга угсралтын ажлын (БУА) зардал гэж үзнэ. БУА-ын дүн дээр нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардал, магадалшгүй ажлын зардал, нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг нэмж тооцож, байгууллагын орлогод бүртгэнэ.

4.2. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

4.2.1. Удирдлага, зохион байгуулалтын зардлыг тооцоход суурь үзүүлэлт болгон төсөвт өртгийн нийт цалингийн санг ашиглана.

4.2.2. Удирдлага, зохион байгуулалтын зардлыг төсөвт өртгийн нийт цалингийн зардлын дүнгийн 63.5 хувиар тооцож, төсөвт тусгана.

4.2.3. Удирдлага, зохион байгуулалтын зардлын бүрэлдэхүүнд дараах зардлууд хамаарна. (Хүснэгт №3)

Хүснэгт №3

№	Зардлын зүйл анги	Нийт зардалд эзлэх хэмжээ (%-иар)
1	Захиргаа, аж ахуйн ажилтны цалин	53.5
2	Захиргаа, аж ахуйн ажилтны ЭМД, НДШ	6.3
3	Сул зогсолтын үеийн ЭМД, НДШ	3.9
4	Шуудан холбооны зардал	0.9
5	Газрын төлбөр	1.5
6	Албан томилолтын зардал	1.5
7	Удирдлагын барилга байгууламжийн ашиглалтын зардал	12.2
8	Удирдах болон ИТА-ны үйлчилгээний автомашины зардал	5.1
9	Сургалтын зардал	0.3
10	Биет бус хөрөнгийн элэгдэл	0.4
11	Зөвлөгөө, мэдээлэл, аудитын зардал	1.5
12	Хэвлэн олшруулах техник хэрэгслийн ашиглалтын зардал	4.1
13	ТУЗ, хяналтын зөвлөл, бусад дээд байгууллагад төлөх шимтгэл	2.5
14	Бичиг хэрэг, техникийн ном, норм дүрэм худалдан авах, архивын зардал	0.3
15	Шинэ санаачлага, оновчтой санал хэрэгжүүлэх зардал	0.2
16	Тендертэй холбоотой зардал	0.4

17	Кемпийн үйл ажиллагааны зардал	5.4
	Удирдлага, зохион байгуулалтын зардлын дүн	100

4.3. АШГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

4.3.1. Ашгийн зардал нь байгууллагын үйл ажиллагааг тогтвортой явуулах, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах зорилготой. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалт,
- ✓ Үндсэн хөрөнгийн засвар, шинэчлэлт,
- ✓ Эргэлтийн хөрөнгийн өсөлт,
- ✓ Ажилтан болон өндөр настанд үзүүлэх тэтгэмж, урамшуулал,
- ✓ Шагнал, урамшуулал,
- ✓ Мэргэжилтэн бэлтгэх,
- ✓ Холбогдох татвар, хураамж,

4.3.2. Ашгийн зардлыг төсөвт өртгийн тооцооны шууд зардлын дүнгийн 15 хувиар тооцож, төсөвт тусгана.

4.3.3. Ашгийн зардлын бүтцийг Хүснэгт №4-т үзүүлэв.

Хүснэгт №4

№	Зардлын зүйл анги	Нийт зардалд эзлэх хэмжээ, %-иар
1	Үндсэн хөрөнгийн засвар, шинэчлэлт	14.3
2	Эргэлтийн хөрөнгийн өсөлт	16.3
3	Ажилтанууд болон өндөр настанд олгох тэтгэмж	2.1
4	Шагнал урамшуулал	2.7
5	Баяр ёслолын үйл ажиллагаа	3.6
6	Хууль журамд заасан хөнгөлөлт	5.0
7	Мэргэжилтэн бэлтгэх зардал	12.5
8	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, амралт сувилалын зардал	0.5

9	Орлогын албан татвар	3.5
10	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1.1
11	Зээл (лизинг)-ээр худалдан авсан машин механизм, тоног төхөөрөмжийн үндсэн төлбөр болон хүүгийн төлөлт, шимтгэлийн зардал	38.4
	Ашгийн зардлын дүн	100

4.4. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

4.4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төсөвт өртгийн шууд зардлын дүнгийн 2.5 хувиар тооцож, төсөвт тусгана.

4.4.2. Энэхүү зардал нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” болон “Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм”-ийн хүрээнд авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны шаардлагыг хангах зардал юм.

4.5. ДААТГАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

4.5.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын даатгалын зардлыг төсвийн шууд зардлын дүнгийн 0.4 хувиар тооцож, төсөвт тусгана.

4.5.2. Даатгал нь ажил эхлэх үеэс хэрэгжиж дуусах хугацаанд учирч болзошгүй аливаа эрсдэл, хохирлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, мөн учирсан хохирлыг нөхөн төлөх зорилготой байна.

4.5.3. Даатгалын зардалд дараах төрлийн даатгал багтсан. Үүнд:

- ✓ Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал,
- ✓ Техник, тоног төхөөрөмжийн даатгал,
- ✓ Ажиллагсадын даатгал,
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хариуцлагын даатгал,

5. НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО

5.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

5.1.1. Нэгдсэн төсвийн тооцоогоор авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нийт төсөвт өртгийн хэмжээг тодорхойлно. (Маягт №10)

5.1.2. Нийт хөрөнгө оруулалтын хэмжээг Маягт №11-н дагуу тодорхойлно. Хөрөнгө оруулалтын II, III бүлэгт хамаарах зардал, ажлын хөлсийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар болон холбогдох бусад байгууллагатай хамтран гаргасан шийдвэрээр тогтооно. Эдгээр шийдвэр нь авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг тооцох нормын салшгүй хэсэг нь байна.

5.2. ТУСГАЙ ТӨРЛИЙН АЖИЛ БА ЗАРДЛЫН ТООЦОО

5.2.1. Төсвийн норм, нормативт тусгагдаагүй боловч хөрөнгө оруулалтад зайлшгүй орох зардлыг тусгай төрлийн зардал гэнэ. Үүнд:

- ✓ Газрын төлбөр,
- ✓ Авто замын зурваст орсон барилга, байгууламжийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлбөр,
- ✓ Засгийн газрын шийдвэрээр тогтоосон хөнгөлөлт, нэмэлт төлбөр,

5.2.2. Тусгай төрлийн зардлын хэмжээг Монгол Улсын Газрын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Газрын төлбөрийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, баримт бичгийг үндэслэн тогтооно.

5.3. ХАЙГУУЛ, ЗУРАГ ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

5.3.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын хайгуул, зураг төслийн зардлыг тухайн үеийн мөрдөгдөж буй хүчин төгөлдөр тушаал шийдвэр, норм дүрмийн дагуу тооцно.

5.3.2. Инженерийн хайгуул ба зураг төслийн зардлын хүрээнд:

- ✓ Инженерийн хайгуул, инженер-геологийн судалгаа, инженер-геодезийн ажлын зардал нь авто замын трассын хайгуул, судалгаа, трасс сонголтын үндсэн ажлууд болон тэдгээрийг гүйцэтгэхэд шаардагдах бэлтгэл ба дагалдах ажлуудыг багтаана.
- ✓ Зураг төслийн зардал нь Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах олон улс, улсын чанартай авто зам, нийслэлийн авто зам, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг төсөллөх, зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлуудыг хамаарна.
- ✓ Зураг, төсөвт магадлал хийх зардал нь авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журмын дагуу хийгдэх ажлууд хамаарна.

5.3.3. Байгаль орчин болон түүх, соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах судалгааны ажил нь зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тусгагдаагүй тохиолдолд, энэхүү ажлын зардлыг захиалагч байгууллагатай харилцан зөвшилцөж, авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг тооцох нормын төсвийн нэгдсэн тооцооны “Бусад зардал” бүлэгт тусгаж болно.

5.4. НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО

5.4.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах нийт зардлыг нэгтгэн тооцсоныг “Нэгдсэн төсвийн тооцоо” гэнэ. Нэгдсэн төсвийн тооцоо нь дараах гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

1. Шууд зардал – тухайн ажлыг гүйцэтгэхэд шууд хамаарах зардал буюу нийт цалин, ЭМ, НД-ын шимтгэлийн зардал, материал, машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн зардал, ажлын багаж хэрэгслийн элэгдэл, ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал,

2. Шууд бус зардал – ажлын гүйцэтгэлд шууд бусаар хамаарах нэмэлт зардлууд буюу удирдлага, зохион байгуулалтын зардал, ашгийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал, даатгалын зардал,

3. Бусад зардал – авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын явцад гардаг тусгай болон нэмэлт зардлууд буюу нүүлгэн шилжүүлэлт, түр барилгын элэгдэл, магадалшгүй ажил, НӨАТ, техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал, захиалагчийн хяналтын зардал, авто замын норм, нормативын сангийн шимтгэл, бусад зардлууд гэх мэт

5.4.2. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил гүйцэтгэх явцад зайлшгүй хийгдэх нэмэлт ажлыг “Магадалшгүй ажил” нэрлэнэ. Магадалшгүй ажлын зардлыг барилга угсралтын ажлын дүнгийн 2 хувиар тооцож, нэгдсэн төсвийн тооцоонд тусгана.

5.4.3. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал болон гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засвар, ээлжит засварын ажлын төсөвт магадалшгүй ажлын зардлыг тусгахгүй.

5.4.4. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын магадалшгүй ажлын зардлыг захиалагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл болон батлагдсан төсвийн тооцоог үндэслэн санхүүжүүлнэ.

5.4.5. Авто зам, замын байгууламжийн төсөвт өртөгт Нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) хэмжээг Монгол Улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай

хууль”-д заасны дагуу барилга угсралтын ажлын дүнгийн 10 хувиар тооцож нэгдсэн төсвийн тооцоонд тусгана.

5.4.6. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртөгт техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлыг барилга угсралтын ажлын дүнгийн 5 хувиар тооцож, нэгдсэн төсөвт тусгана.

5.4.7. Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлыг төсөвт өртөгт тооцсон тохиолдолд захиалагчийн хяналтын зардлыг техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлын дүнгээс Хүснэгт №5, Хүснэгт №6-д заасан хувь хэмжээгээр тооцно.

5.4.8. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд 5.4.7-д заасан зохицуулалт хамаарахгүй. Энэ тохиолдолд захиалагчийн хяналтын зардлын хэмжээг урьдчилан тодорхойлж, төсөвт тусгана.

Хүснэгт №5

№	Замын урт, км-ээр	Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлын дүнгээс
1	0-10	3%
2	11-50	2%
3	51-ээс дээш	1%

Хүснэгт №6

№	Гүүрийн урт, у/м-ээр	Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлын дүнгээс
1	0-50	3%
2	51-100	2%
3	101-ээс дээш	1%

5.4.9. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал болон гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засвар, ээлжит засварын ажилд захиалагчийн хяналтын зардлыг барилга угсралтын ажлын дүнгийн 4 хувиар тооцно.

5.4.10. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, төсвийг шинэчлэх, дахин магадлал хийхтэй холбоотой зардал болон бусад инженерийн байгууламжийг барих, буулгах зардлыг “Нэгдсэн төсвийн тооцоо”-ны “Бусад зардал” бүлэгт тусгаж болно.

5.4.11. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын явцад гарсан бага хэмжээний нэмэлт ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах хүн хүч, бараа материал, машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн зардлыг зөвлөх компанийн зөвшөөрлөөр “Өдрөөр тооцох ажил”-ын зардлаас санхүүжүүлнэ.

5.4.12. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын явцад нэмэлт зардал бий болоогүй нөхцөлд нэгдсэн төсвийн тооцоонд тусгагдсан “Магадалшгүй ажил”-ын зардлыг санхүүжүүлэхгүй бөгөөд улсын төсөвт буцаан төвлөрүүлнэ.

5.4.13. “Нэгдсэн төсвийн тооцоо”-ны “Бусад зардал”-д тухайн төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай боловч үндсэн ажлын нэгж үнэд багтаагүй зардлыг хэлнэ. Үүнд:

- ✓ Авто замын борооны ус зайлуулах ажлын зардал
- ✓ Гэрэлтүүлгийн ажлын зардал
- ✓ Дохиолол, холбооны ажлын зардал
- ✓ Инженерийн шугам сүлжээний ажлын зардал
- ✓ Зураг төсөл, төсөв шинэчлэх үнэ
- ✓ Өдрөөр тооцох ажил
- ✓ Бусад зардлууд гэх мэт

5.4.14. Бусад зардлын төсөв, холбогдох баримт бичгийг авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт хавсаргана.

5.4.15. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу сүүлийн хоёр жилийн дотор боловсруулагдсан, магадлалын дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл, төсөвтэй байх шаардлагыг хангасан байна.

5.4.16. Захиалагч байгууллагын хүсэлтээр авто зам, замын байгууламжийн зураг төсөл зохиогчтой харилцан тохиролцож гэрээ байгуулсан нөхцөлд зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлж болно.

5.4.17. Авто замын норм, нормативын сангийн шимтгэлийн зардлыг авто зам, замын байгууламжийн төсөвт өртгийн тооцооны барилга угсралтын ажлын дүнгийн 0.4 хувиар тооцож, авто замын норм, нормативын санд заавал төвлөрүүлнэ.

5.5. НЭГЖ ҮНЭ БА НИЙТ ҮНИЙН ТООЦООНЫ АРГАЧЛАЛ

5.5.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын үе шатны ажлын нэгж үнийг тодорхойлж, гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээнд үндэслэн төлбөр тооцох аргачлалыг “нэгж үнэ ба нийт үнийн арга” гэнэ. Энэхүү аргачлалыг төсөвт өртөг

тооцх, тендерийн үнийн санал боловсруулах, гэрээний гүйцэтгэлийг санхүүжүүлэх болон төлбөр тооцооны үндэслэл болгон ашиглана.

5.5.2. Ажлын зураг төсөл, техникийн шаардлага, тоо хэмжээг үндэслэн авто замын барилга, засварын ажлын үе шатны ажлын нэгж үнэ, нийт үнийг нэгдсэн төсвийн тооцоогоор тодорхойлно.

5.5.3. Үе шатны ажлын нэгж үнэд нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-г багтаан тооцож болно. Хэрэв нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-г нэгж үнэд тооцсон бол төсвийн тайлбар бичигт энэ талаарх мэдээллийг оруулна.

5.5.4. Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, авто замын норм, нормативын сангийн шимтгэл, өдрөөр тооцох ажил болон бусад зардлыг төсвийн тооцооны үе шатны, бие даасан ажил бүрийн нэгж үнэд багтаан тооцох, эсвэл тусад нь тооцож болно.

5.5.5. Гүйцэтгэгч нь аль нэг нэгж үнэ ба нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд уг ажлыг гүйцэтгэсэн ч захиалагч төлбөр хийхгүй бөгөөд тухайн зардлыг бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

5.5.6. Нэгж үнэ ба нийт үнэд ямар зардлууд багтсан болохыг (Жишээ: нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардал, техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, авто замын норм нормативын сангийн шимтгэл, нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад гэх мэт) нэгж үнэ ба нийт үнийн зардлын тооцоо болон төсвийн тайлбар бичигт тодорхой тусгана.

5.5.7. Дээрх зардлууд нь нэгж үнэд тусгагдаагүй тохиолдолд тусад нь тооцож нийт өртөгт багтаана.

5.5.8. Нэгж үнэ болон нийт үнийг “Авто зам, замын байгууламжийн төсөвт өртөг тооцох норм”-д заасны дагуу дараах аргачлалаар тооцно. Үүнд:

1 – Ажилтны хөдөлмөр зарцуулалт, нийт цалин, ЭМ, НД-ын шимтгэлийн зардал:
Ажилтны хөдөлмөр зарцуулалт, нийт цалин, ЭМ, НД-ын шимтгэлийн зардлыг Маягт №1А, 1Б, Хавсралт №6-д заасны дагуу тооцно.

2 – Материалын зардал:

Төсвийн суурь нормоос материалын хэрэгцээг тодорхойлж, хаягдал, хорогдол, сийрэгжилтийн итгэлцүүр тооцон нийт хэмжээг гаргаж, материалын зах зээлийн жишиг үнэд тулгуурлан Маягт №2А, №2Б-д заасны дагуу тооцно.

3 – Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал:

Төсвийн суурь нормд заасан машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл, ажиллах хугацаа, нэг машин цагийн жишиг үнийг ашиглан Маягт №3А, №3Б-д заасны дагуу тооцно.

4 – Тээврийн зардал:

Материалын нийт жинг нэгж хүндийн жингээр үржүүлж, тээврийн зай, ачааны зэрэгт тохируулан автомашинаар ачаа тээвэрлэх 1 тн/км-ын жишиг тарифаар үржүүлж тооцно. (Маягт №4А, №4Б)

5 – Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардал, Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал:

Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардал болон ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардлыг 3.6 ба 3.7 дугаар зүйлд заасны дагуу тооцно.

6 – Шууд зардал:

Нийт цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл + материалын зардал + машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал + тээврийн зардал + ажлын багаж хэрэгслийн зардал + ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал = шууд зардал.

7 – Удирдлага, зохион байгуулалтын зардал:

Удирдлага, зохион байгуулалтын зардлыг төсөвт өртгийн тооцооны нийт цалингийн зардлын дүнгийн 63.5 хувиар тооцно.

8 – Ашгийн зардал:

Ашгийн зардлыг төсөвт өртгийн тооцооны шууд зардлын дүнгийн 15 хувиар тооцно.

9 – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардлыг төсөвт өртгийн тооцооны шууд зардлын дүнгийн 2.5 хувиар тооцно.

10 – Даатгалын зардал:

Даатгалын зардлыг төсөвт өртгийн тооцооны шууд зардлын дүнгийн 0.4 хувиар тооцно.

11 – Барилга угсралтын ажлын зардал:

Шууд зардал + удирдлага, зохион байгуулалтын зардал + ашгийн зардал + хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал + даатгалын зардал

12 – Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардал:

Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлыг энэ нормын 3.8 дугаар зүйлд заасны дагуу тооцно.

13 – Магадалшгүй ажлын зардал:

Магадалшгүй ажлын зардлыг төсөвт өртгийн тооцооны БУА-ын дүнгийн 2 хувиар тооцно.

14 – Нэмэгдсэн өртгийн албан татвар:

Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт өртгийн тооцооны БУА-ын дүнгийн 10 хувиар тооцно.

15 – Техник технологийн хяналтын зардал:

Техник технологийн хяналтын зардлыг төсөвт өртгийн тооцооны БУА-ын дүнгийн 5 хувиар тооцно.

16 – Захиалагчийн хяналтын зардал:

Захиалагчийн хяналтын зардлыг энэ нормын 5.4.9, 5.4.10, 5.4.11 дүгээр заалтын дагуу тооцно.

17 – Авто замын норм, нормативын сангийн шимтгэлийн зардал:

Авто замын норм, нормативын сангийн шимтгэлийг төсөвт өртгийн тооцооны БУА-ын дүнгийн 0.4 хувиар тооцно.

18 – Бусад зардал:

Шаардлагатай тохиолдолд бусад зардлыг энэ нормын 5.4.13, 5.4.17 дугаар заалтын дагуу тооцож нэгж үнэд тусгаж болно.

19 – Төсөвт өртөг:

Барилга угсралтын ажлын дүн + Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардал + Магадалшгүй ажлын зардал + Нэмэгдсэн өртгийн албан татвар + Техник технологийн хяналтын зардал + Захиалагчийн хяналтын зардал + Авто замын норм, нормативын сангийн шимтгэл + Бусад зардал = Төсөвт өртөг

20 – Нэгж үнийг тооцох:

Нийт төсөвт өртгийг тухайн ажлын тоо хэмжээнд хувааснаар нэгж үнийг тодорхойлно.

Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нэгж үнэ ба нийт үнийг дараах гурван аргын аль нэгээр тооцож болно. Үүнд:

1 дүгээр арга: Шууд зардал, шууд бус зардал, бусад зардлыг нэгтгэн ажлын тоо хэмжээнд хуваах.

1. Шууд зардал:

- ✓ Нийт цалин
- ✓ Материал
- ✓ Машин механизм
- ✓ Тээвэр
- ✓ Эрүүл мэнд, нийгмийн даатгал
- ✓ Багаж хэрэгслийн элэгдэл
- ✓ Ажилтнуудад үйлчлэх зардал

2. Шууд бус зардал:

- ✓ Удирдлага, зохион байгуулалтын зардал
- ✓ Ашгийн зардал

- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал
- ✓ Даатгал

3. Бусад зардал:

- ✓ Нүүлгэн шилжүүлэх, түр барилгын элэгдлийн зардал
- ✓ Магадалшгүй ажил
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар
- ✓ Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал
- ✓ Захиалагчийн хяналтын зардал
- ✓ Авто замын норм нормативын сангийн шимтгэлийн зардал
- ✓ Бусад нэмэлт зардал

4. Нэгж үнэ = (Шууд зардал + Шууд бус зардал + Бусад зардал) / Ажлын тоо хэмжээ

2 дугаар арга: Барилга угсралтын ажлын дүнг үндэслэн нэгж үнийг тооцох. Дараах бусад зардлыг тусад нь тооцож болно. Үүнд:

- ✓ Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардал
- ✓ Магадалшгүй ажлын зардал
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татварын зардал
- ✓ Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал
- ✓ Захиалагчийн хяналтын зардал
- ✓ Авто замын норм нормативын сангийн шимтгэлийн зардал
- ✓ Бусад зардал

1. Шууд зардал:

- ✓ Нийт цалин
- ✓ Материал
- ✓ Машин механизм
- ✓ Тээвэр
- ✓ Эрүүл мэнд, нийгмийн даатгал
- ✓ Багаж хэрэгслийн элэгдэл
- ✓ Ажилтнуудад үйлчлэх зардал

2. Шууд бус зардал:

- ✓ Удирдлага, зохион байгуулалтын зардал
- ✓ Ашгийн зардал
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал
- ✓ Даатгал

3. Нэгж үнэ = (Шууд зардал + Шууд бус зардал) / Ажлын тоо хэмжээ

3 дугаар арга: Барилга угсралтын ажлын дүн дээр зөвхөн шаардлагатай бусад зардлыг нэмж тооцох. (Жишээлбэл: Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын

элэгдэл, НӨАТ гэх мэт) Гүйцэтгэлийн төсөвт өртгийг нэгж үнэ ба нийт үнээр гаргах тохиолдолд ажлын тоо хэмжээ нь тухайн ажлын нэгж үнэд нөлөөлөх учраас нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлыг тусад нь тооцох зайлшгүй шаардлагатай.

1. Шууд зардал:

- ✓ Цалин
- ✓ Материал
- ✓ Машин механизм
- ✓ Тээвэр
- ✓ Эрүүл мэнд, нийгмийн даатгал
- ✓ Багаж хэрэгслийн элэгдэл
- ✓ Ажилтнуудад үйлчлэх зардал

2. Шууд бус зардал:

- ✓ Удирдлага, зохион байгуулалтын зардал
- ✓ Ашгийн зардал
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал
- ✓ Даатгал

3. Бусад зардал (шаардлагатай зардал)

4. Нэгж үнэ = (Шууд зардал + Шууд бус зардал + Шаардлагатай бусад зардал) /
Ажлын тоо хэмжээ

5.6. ТӨВӨГШЛИЙН ИТГЭЛЦҮҮР ТООЦОХ

5.6.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэх явцад ажиллах орчны нөхцөл болон цаг агаарын байдал нь ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжид шууд нөлөөлдөг. Үүнд дараах нөхцөлүүд хамаарна.

- ✓ Хөдөлгөөн тасралтгүй үргэлжилж буй нөхцөлд ажиллах,
- ✓ Уулархаг ба өндөр уулын бүсэд ажиллах,
- ✓ Хүйтэн уур амьсгал, цаг агаарын нөхцөлд ажиллах

5.6.2. Ажиллах орчны хүчин зүйлс нь хөдөлмөрийн бүтээмж, барилга, засварын ажлын чанар, технологийн горимд сөргөөр нөлөөлж, эрсдэлийг нэмэгдүүлдэг тул ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, ажлын төлөвлөгөө болон төсөвт өртгийг бодитой тооцох зорилгоор төвөгшлийн итгэлцүүрийг ашиглана.

5.6.3. Зураг төсөл, ажлын даалгавар, гэрээний баримт бичиг, захиалагчийн шийдвэрийг үндэслэн “Хөдөлгөөнтэй нөхцөлд ажиллах”, “Уулархаг ба өндөр уулын

бүсэд ажиллах”, “Хүйтэн нөхцөлд ажиллах” гэсэн гурван төрлийн төвөгшлийн итгэлцүүрийн аль нэгийг сонгож төсөвт өртгийг тооцно. Хэрэв дээрх баримт бичигт энэ талаар тусгагдаагүй бол төвөгшлийн итгэлцүүр тооцохгүй.

5.6.4. Төсөвт өртгийн тооцоонд төвөгшлийн итгэлцүүрийг тооцсон тохиолдолд үндэслэл, цагийн нормыг хэдэн хувиар нэмэгдүүлсэн талаарх мэдээллийг ажлын тоо хэмжээний тодорхойлолт болон төсвийн тайлбар бичигт заавал тусгана.

5.6.5. Замын нэг урсгалаар автомашины байнгын хөдөлгөөн явагдаж байх үед нөгөө урсгалд барилга, засварын ажил хийгдэх бол ажилтны хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног төхөөрөмжийн цагийн нормыг 1.2 гэсэн итгэлцүүрээр нэмэгдүүлнэ.

5.6.5.1. Хөдөлмөрийн бүтээмж буурах хүчин зүйлс:

- ✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлж байгаагаас шалтгаалж ажлын цагийн алдагдал нэмэгдэх
- ✓ Сул зогсолт ихсэж машин механизм, тоног төхөөрөмжийн бүтээмж буурах, түлш, шатахуун илүү зарцуулагдах

5.6.6. Уулархаг ба өндөр уулын бүсэд ажиллах нь ердийн нөхцөлд ажиллахтай харьцуулахад төвөгтэй, эрсдэлтэй учраас төвөгшлийн итгэлцүүрийг төсөвт тооцно.

5.6.6.1. Газрын гадаргуугийн налуу нь 12.5%-иас их, 2 км-ээс багагүй зайд үргэлжилсэн тохиолдолд “Уулархаг ба өндөр уулын бүс” гэж үзнэ. Энэ тохиолдолд ажилтны хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног төхөөрөмжийн цагийн нормыг 1.2 гэсэн итгэлцүүрээр нэмэгдүүлнэ.

5.6.6.2. Хөдөлмөрийн бүтээмж буурах хүчин зүйлс:

- ✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, түр зам хийх боломжгүйгээс ажлын цагийн алдагдал нэмэгдэх
- ✓ Огцом өгсүүр, уруудах газарт ажиллах үед машин механизм, тоног төхөөрөмжийн бүтээмж буурах, түлш, шатахуун илүү зарцуулах
- ✓ Газар нутгийн налуу, хэвгий байдал нь ажил гүйцэтгэхэд хүндрэл учруулах
- ✓ Уулын оргил, уруу руу материал, тоног төхөөрөмж зөөвөрлөх нь цаг хугацаа, хүч хөдөлмөр ихээр шаарддаг.
- ✓ Цаг агаарын хүнд нөхцөл (салхи, цас, мөс гэх мэт) нь ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлдөг.
- ✓ Аюулгүй байдлыг хангах, ослоос урьдчилан сэргийлэхэд илүү анхаарал хандуулах шаардлагатай.

5.6.7. Хүйтэн нөхцөлд барилга, засварын ажил гүйцэтгэх тохиолдолд ажилтны хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног төхөөрөмжийн цагийн нормыг 1.15 гэсэн итгэлцүүрээр нэмэгдүүлнэ. Энэ нь агаарын хасах температурын сөрөг нөлөөллөөс шалтгаалан гарч буй нэмэлт зардлыг тооцох зорилготой.

5.6.7.1. Хөдөлмөрийн бүтээмж буурах хүчин зүйлс:

- ✓ Дулаан хувцас, бээлийтэй ажиллах үед хөдөлгөөний эвсэл буурах, гарын ур дүй саарах,
- ✓ Ажлын талбайн харагдац муудах, мөс, цаснаас шалтгаалан гулсалт үүсэх, материал, багаж, тоноглолыг цэвэрлэх шаардлага нэмэгдэх,
- ✓ Гадна агаарын температур -20°C -аас -35°C хүртэл буурахад ажилчид дулаацахаар завсарлах,
- ✓ Машин механизм, тоног төхөөрөмжийн бүтээмж буурах, түлш, шатахууны зарцуулалт нэмэгдэх,

5.6.7.2. Хүйтэн нөхцөлд ажиллах төвөгшлийн итгэлцүүрийг жил бүрийн 12 дугаар сарын 01-нээс дараа жилийн 3 дугаар сарын 01 хүртэл өвлийн улиралд хийгдэх ажлуудад тооцно.

5.6.8. Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил, материалын шинжилгээ, туршилтын ажил, авто зам, замын байгууламжийг улсын ашиглалтад оруулах, үйлдвэр, заводыг ачиж буулгах, угсрах, хураах, туршилт, судалгаа хийх, барилгын талбайн бэлтгэл, үйлдвэрлэлийн бэлтгэл гэх мэт технологийн бус бүлгийн ажлуудад төвөгшлийн итгэлцүүр тооцохгүй.

5.6.9. Нэгдсэн төсвийн тооцоонд төсвийн нүүр хуудас, тайлбар бичгийг хавсаргана. Тайлбар бичигт дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:

- ✓ Захиалагч, зураг төслийн гүйцэтгэгч байгууллагын нэр
- ✓ Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нэр төрөл, онцлог
- ✓ Зам, гүүрийн урт, хүчин чадал,
- ✓ Төслийн өртөг, нэгж үнэ
- ✓ Төслийн байршил
- ✓ Төсвийн тооцооны нормативын хувь хэмжээ, ашигласан норм, дүрэм, тушаал шийдвэр гэх мэт

ТӨСВИЙН ТООЦООНЫ МАЯГТУУД, ТӨСӨВТ ӨРТӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Барилга байгууламжийн нэр, байршил:

Огноо:

АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨР ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

Маягт №1А

№	Үндэслэл	Ажлын нэр	х.н	Ажлын тоо хэмжээ	Ажил, мэргэжлийн нэр	Мэргэжлийн зэрэг	Нэгж хөдөлмөр зарцуулалт, хүн/цаг	Бүгд хөдөлмөр зарцуулалт, хүн/цаг	Төвөгшлийн итгэлцүүр	Бүгд хөдөлмөр зарцуулалт, хүн/цаг (төвөгшил тооцсон)
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
								5*8		9*10
НИЙТ ХӨДӨЛМӨР ЗАРЦУУЛАЛТ (ХҮН/ЦАГ)								+		+

Маягт №1А, Ажилтны хөдөлмөр зарцуулалтын тооцоо хийх (1):

№	Баганы дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	2-4	Үндэслэл, ажлын нэр, хэмжих нэгж	Төсвийн нормоос авна.
2	5	Ажлын тоо хэмжээ	Ажлын зураг, техникийн шаардлага, тоо хэмжээний тодорхойлолт
3	6-8	Ажил мэргэжлийн нэр, зэрэг, нэгж хөдөлмөр зарцуулалт, (хүн/цаг)	Төсвийн нормоос авна.
4	9	Бүгд хөдөлмөр зарцуулалт, хүн/цаг	Багана 5 × Багана 8 = Багана 9
5	10	Төвөгшлийн итгэлцүүр	Төвөгшил тооцсон тохиолдолд “Хөдөлгөөнт”, “Уулархаг”, “Хүйтэн нөхцөл” –ийн зөвхөн аль нэгийг тооцно.
6	11	Бүгд хөдөлмөр зарцуулалт, хүн/цаг (төвөгшил тооцсон)	Хэрэв төвөгшил тооцогдсон бол Багана 9 × Багана 10 = Багана 11

Анхаарах зүйлс:

- ✓ Багана 10-ыг зөвхөн тухайн ажилд төвөгшлийн итгэлцүүр тооцсон тохиолдолд бөглөнө. Төвөгшил тооцоогүй тохиолдолд итгэлцүүрийг 1.0 гэж авна.
- ✓ Төвөгшлийн итгэлцүүр хэрэглэх үндэслэл, тайлбарыг гэрээний баримт бичиг болон ажлын тоо хэмжээний тодорхойлолтод заавал тодорхой тусгасан байна.

НИЙТ ЦАЛИН, ЭМ, НД-ЫН ШИМТГЭЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Маягт №1Б

№	Үндэслэл	Ажлын нэр	х.н	Ажлын тоо хэмжээ	Ажил, мэргэжлийн нэр, зэрэг	Бүгд хөдөлмөр зарцуулалт, хүн/цаг (төвөгшил тооцсон)	Ажилтны тарифт цалин, төгрөг	Ажилтны үндсэн цалин, төгрөг	Ажилтны нэмэгдэл цалин 30%, төгрөг	Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл цалин 10.8%, төгрөг	Ажилтны алслалтын нэмэгдэл цалин, төгрөг (нормд зааснаар)	Ажилтны бүгд цалин, төгрөг	ЭМ, НД-ын даатгалын шимтгэл (хувиар)	ЭМ, НД-ын даатгалын шимтгэлийн зардал	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	
								7*8	9*10	9*11	9*12	9+10+11+12		13*14	
1		Ажилтны бүгд цалин (АБЦ)							+	+	+	+	АБЦ	-	+
2		Машин механизмын операторын цалин (МОЦ)											МОЦ	14.5%	+
3		Тээврийн жолоочийн цалин (ТЖЦ)											ТЖЦ	14.5%	+
4		Нэмэгдэл цалин (НЦ)											НЦ=(МОЦ+ТЖЦ)*30%	14.5%	+
5		Инженер техникийн ажилтны цалин (ИТАЦ)											ИТАЦ=(АҮЦ+МОЦ+ТЖЦ)*25%	14.5%	+
6		Алслалтын нэмэгдэл цалин (АНЦ)											АНЦ=(МОЦ+ТЖЦ+ИТАЦ) * (нормд зааснаар)	14.5%	+
7		НИЙТ ЦАЛИН / ЭМ, НД-ЫН ШИМТГЭЛИЙН ДҮН											НЦ= АБЦ+МОЦ+ТЖЦ+НЦ+ ИТАЦ+АНЦ		+

Маягт №1Б: Нийт цалин, Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүрэлдэхүүн (1-7 дугаар мөр)

- 1 - Ажилтны бүгд цалин (АБЦ)
- 2 – Машин механизмын операторын цалин (МОЦ)
- 3 - Тээврийн жолоочийн цалин (ТЖЦ)
- 4 - Нэмэгдэл цалин (НЦ)
- 5 – Инженер техникийн ажилтны цалин (ИТАЦ)
- 6 - Алслалтын нэмэгдэл цалин (АНЦ)
- 7 - Нийт цалин (НЦ)

Маягт №1Б: Нийт цалин, Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тооцох:

№	Баганы дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	2-6	Үндэслэл, ажлын нэр, хэмжих нэгж, тоо хэмжээ, ажил мэргэжлийн нэр, зэрэг	Маягт №1А, Багана 2-7
2	7	Бүгд хөдөлмөр зарцуулалт, хүн/цаг	Маягт №1А-н 11 дүгээр баганы дүн
3	8	Тарифт цалин, төгрөг (ТЦ)	Мэргэжлийн зэрэгт харгалзах ажилтны тарифт цалинг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тушаалын хавсралтаас авна.
4	9	Ажилтны үндсэн цалин, төгрөг	Багана 7 × Багана 8 = Багана 9
5	10	Нэмэгдэл цалин 30%, төгрөг (АНЦ)	Багана 9 × 30% = Багана 10
6	11	Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл цалин (10.8%), төгрөг	Багана 9 × 10.8% = Багана 11
7	12	Алслалтын нэмэгдэл цалин, төгрөг (нормд зааснаар)	Багана 9 × нормд зааснаар = Багана 12
8	13	Ажилтны бүгд цалин, төгрөг (АБЦ)	Багана 9 + Багана 10 + Багана 11 + Багана 12 = Багана 13
9	14	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Жагсаалт, журам батлах тухай” 471 дугаар тогтоолын Хавсралт №1, Хавсралт №2-т заасны дагуу Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг төлөх ажил мэргэжлийн жагсаалтын дагуу тооцно. (Хавсралт №6)
10	15	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	Багана 13 × Багана 14 = Багана 15

Анхаарах зүйлс:

- ✓ Ажилтны тарифт цалин (Багана 8), Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл цалин 10.8%-ийг (Багана 11) холбогдох дүрэм журам, тушаал шийдвэр, төсөвт өртөг тооцох нормд заасны дагуу тооцно.
- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлагдсан “Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөл”-д хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад үндэслэн төсвийн нормын хэсгийн бүрэлдэхүүний ажил, мэргэжил нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамаарч байвал (Багана 11) хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл цалинг төсөвт тооцно. Ажил, мэргэжлийн жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд тухайн хууль тогтоомж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Маягт №1Б, Машин механизмын операторын цалин тооцох (2):

№	Мөрийн дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	2	Машин механизмын операторын цалин	Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын тооцооны цалингийн зардал 8.7% (Маягт №3А, №3Б)

Маягт №1Б-н Тээврийн жолоочийн цалин тооцох (3):

№	Мөрийн дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	3	Тээврийн жолоочийн цалин	Тээврийн зардлын тооцооны цалингийн зардал 8.7% (Маягт №4А, №4Б)

Маягт №1Б-н Нэмэгдэл цалин тооцох (4):

№	Мөрийн дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	4	Нэмэгдэл цалин	Нэмэгдэл цалинг машин механизмын операторын цалин, тээврийн жолоочийн цалингийн нийлбэр дүнгээс 30 хувиар тооцно.

Маягт №1Б-н Инженер техникийн ажилтны цалин тооцох (5):

№	Мөрийн дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	5	Инженер техникийн ажилтны цалин	Инженер техникийн ажилтны цалинг ажилтны үндсэн цалин, машин механизмын операторын цалин, тээврийн жолоочийн цалингийн нийлбэр дүнгээс 25 хувиар тооцно..

Маягт №1Б-н Алслалтын нэмэгдэл цалин тооцох (6):

№	Мөрийн дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	6	Алслалтын нэмэгдэл цалин	Алслалтын нэмэгдэл цалинг тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторын цалин, инженер техникийн ажилтны цалингийн нийлбэр дүнгээс нормд заасны дагуу тооцно.

Маягт №1Б-н Нийт цалин тооцох (7):

№	Мөрийн дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
---	---------------	---------	----------------------

1	7	Нийт цалин	Ажилтны бүгд цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторын цалин, инженер техникийн ажилтны цалин, нэмэгдэл цалин, алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэрээр тогтооно.
---	---	------------	---

МАТЕРИАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Маягт №2А

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ	Материалын нэр	Материалын нэгж орц	Сийрэгжилтийн коэф	Материалын нийт орц	Материалын нэгж үнэ, төгрөг	Материалын бүгд үнэ, төгрөг
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
		Нийт дүн								+

Маягт №2А тооцоо хийх тайлбар:

№	Бананы дугаар	Агуулга	Тооцоолол ба тайлбар
1	2-4	Үндэслэл, ажлын нэр, хэмжих нэгж, тоо хэмжээ	Төсвийн норм, тоо хэмжээний тодорхойлолт, Маягт №1-н Багана 2 -с Багана 5 хүртэл
2	5-7	Материалын нэр, нэгж орц	Төсвийн нормоос авна.
3	8	Сийрэгжилтийн итгэлцүүр	Сийрэг байдлаас нягт байдалд шилжүүлэх итгэлцүүр, Хавсралт №5
4	9	Материалын нийт орц	Багана 4 × Багана 7 х Багана 8 = Багана 9
5	10	Материалын нэгж үнэ (төгрөг)	Материалын нэгж өртөг
6	11	Материалын бүгд үнэ (төгрөг)	Багана 9 × Багана 10 = Багана 11

Тайлбар:

- ✓ Материал сийрэг байдлаас нягт байдалд шилжих үед үүсэх нэгж хүнд, эзэлхүүний өөрчлөлтийг илэрхийлэх "Сийрэгжилтийн итгэлцүүр"-ийг Хавсралт №5 - с авна.
